



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДАД
ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА



ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ
“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТой
УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Тайланг боловсруулсан:

Ц.Болормаа (PhD), МУИС-ийн ХАССТ-ийн захирал

Ө.Гэрэлт-Од (PhD), МУИС-ийн ХАССТ-ийн судлаач

Д.Тунгалаг, МУИС-ийн ХАССТ-ийн судлаач

Т.Хишигдулам, МУИС-ийн ХАССТ-ийн судлаач

Монгол Улсын Их Сургуулийн Хүн амын сургалт, судалгааны төв

Энэхүү “Төсвийн хяналт, шинжилгээ” Иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан гарын авлагыг Европын Холбооноос Монгол Улсын Засгийн газарт үзүүлж буй төсвийн дэмжлэгийн бүрэлдэхүүн “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техник туслалцааны төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий зүйл:

Энэхүү гарын авлага нь төслийн хүрээнд боловсруулагдсан бөгөөд ажлын хэрэгцээнд болон судалгаанд зориулав. Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.



Европын Холбоо
санхүүжүүлэл



Food and Agriculture
Organization of the
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



UN
DP

ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДАД
ЗОРИУЛСАН

ГАРЫН АВЛАГА

2022 оны 1-р сар

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	06
Төсөвт хөндлөнгийн хяналт яагаад тавих ёстой бэ?	07
Бүлэг 1:	
Төсөв, төсвийн мэдээлэл	9
1.1 Төсвийн тухай ойлголт, төсвийн бүрэлдэхүүн	9
1.2 Төсвийн мөчлөг, цаглабар	11
1.3 Төсвийн үндсэн баримт бичиг, тайлан	34
Бүлэг 2.	
Төсвийн үйл явц дахь ИНБ-ын оролцоо	21
2.1 Оролцоот төсөв	21
2.2 Төсвийн үйл явц дахь ИНБ-ын оролцоо	27
2.3 Монгол улс: ИНБ-уудын туршлага	29
Бүлэг 3.	
Төсвийн гүйцэтгэлд хяналт, шинжилгээ хийх аргачлал	33
3.1 Төсвийн хяналт, шинжилгээний ерөнхий арга зүй	33
3.2 Төсвийн баримт бичгийг хяналт, шинжилгээнд ашиглах нь	43
3.3 Төсвийн хяналт, шинжилгээ: улс орнуудын туршлага	53
3.3.1. Хөтөлбөрийн төсөвт шинжилгээ хийх аргачлал – Өмнөд Африк улс	53

3.3.2. Төсвийн орлого, зарлагыг мөшгөх асуулгын арга – Малави улс	56
3.3.3. Худалдан авах ажиллагаанд хяналт хийх арга зүй – Филиппин улс	58
3.3.4. ИНБ/Иргэний аудит – Өмнөд Солонгос улс	60
3.3.5. Төсвийн гүйцэтгэлийг хянах онооны картын арга – Эстони улс	63
3.4 Төсвийн сурталчилгаа, нөлөөлөл	65
НОМ ЗҮЙ	73
ХАВСРАЛТ 1.	76
ХАВСРАЛТ 2.	79
ХАВСРАЛТ 3.	81

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Монгол Улс: Төсвийн үндсэн баримт бичгүүдийг нийтэлсэн байдал	13
Хүснэгт 2: Төсвийн баримт бичгүүд	14
Хүснэгт 3: Төсвийн шинжилгээ хийх ерөнхий удирдамж	37
Хүснэгт 4: Үнэлгээний аргачлалууд	42
Хүснэгт 5: Хүүхдийн эрх, нийгмийн хамгааллын төсвийн хуваарилалт, гүйцэтгэлд хяналт хийсэн арга зүй, үр дүн	53
Хүснэгт 6: Хүүхдийн төсөвт оролцогч талууд	55
Хүснэгт 7: Боловсролд хуваарилагдсан зардал мөшгих ажиллагааны арга зүй, үр дүн	57
Хүснэгт 8: Худалдан авах ажиллагаанд хяналт хийх арга зүй, үр дүн	59
Хүснэгт 9: Аудитын шаардлага, хамрах хүрээ	60
Хүснэгт 10: Аудит хийх хугацаа	61
Хүснэгт 11: Тэнцвэрт онооны картын арга зүй, үр дүн	64
Хүснэгт 12: Төсвийн сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааны нэгтгэл	67
Хүснэгт А1. Монгол Улс: Төсвийн үе шат бүрт төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, ИНБ-ууд хамтран ажиллах төвшин	76

ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

ШИГТГЭЭ 1:	Бразил улсын Порто Алегре хотын “Оролцоот-Төсөв санаачилга”-ын туршлага	24
ШИГТГЭЭ 2:	“Улсын зардлыг мөшгих мониторингийн арга (PETS)”- ын сургамж	25
ШИГТГЭЭ 3:	Швед – E оролцоот төсөв: Туршлага	25
ШИГТГЭЭ 4:	Словак улс – Оролцоот төсвийн аргууд: Туршлага	26
ШИГТГЭЭ 5:	Монгол Улс – Нээлттэй нийгэм форум: Туршлага	30
ШИГТГЭЭ 6:	Монгол Улс – “Иргэд төсвөө хянаана” ИНС: Туршлага	31
ШИГТГЭЭ 7:	Иргэд, хэрэглэгчдийн хүсэлт гомдлын дагуу хийгдсэн хяналт шалгалт, үр дүн – Өмнөд Солонгос	62
ШИГТГЭЭ 8:	Нийгмийн аудит – Арга зүй	69
ШИГТГЭЭ 9:	Нийгмийн аудит – Энэтхэг улс - туршлага	71

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУИС	Монгол улсын их сургууль
ННФ	Нээлттэй нийгэм форум
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ОНХС	Олон нийтийн хөгжлийн сан
ОУВС	Олон улсын валютын сан
ОУТТ	Олон улсын төсвийн түншлэл
ОУТХАБ	Олон улсын төсвийн хамтын ажиллагааны байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТИТБОУС	Төсвийн ил тод байдлын олон улсын санаачилга
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилтууд
УИХ	Улсын их хурал
ХАССТ	Хүн амын сургалт судалгааны төв
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага

Төсөвт хөндлөнгийн хяналт яагаад тавих ёстой бэ?

НҮБХХ-ийн “ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөл Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой. Энэ төслийн хүрээнд төсвийн ил тод байдлыг хангах, хариуцлагыг нэмэгдүүлэх, ИНБ-дад төсвийн шинжилгээ, хяналт хийхэд дэмжлэг үзүүлэх зорилт бүхий олон үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсний нэг нь энэхүү “ГАРЫН АВЛАГА” болж байна.

Монгол Улс сүүлийн жилүүдэд төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг хангах талаар тодорхой санаачилга гарган ажиллаж байна. Төр засгийн зүгээс төсвийн ил тод, нээлттэй байдлын талаарх хууль, эрхзүйн өргөн хүрээтэй зохицуулалтыг бий болгож, “Иргэдийн төсөв” эмхэтгэлээр төсвийн мэдээ, мэдээллийг олон нийтэд цаг тухайд нь хүргэхийг зорьж байна.

Төсвийн үйл явц дах олон нийтийн оролцоо, тэр дундаа иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах нь төсвийн ил тод байдал, хариуцлага, үр ашгийг дээшлүүлэх боломжийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэртэй. Нөгөө талаар, олон нийт төсвийн орлого бүрдэлт, зарцуулалт, хуваарилалт, хөрөнгө оруулалт, гүйцэтгэлийн талаар гаргасан төр засгийн шийдвэрүүдийг хянаж, хариуцлага тооцох, ялангуяа төсвийн хуваарилалттай холбогдсон бодлогын зорилтууд биелэгдсэн эсэхийг мэдэх эрхтэй.

Иргэний нийгмийн байгууллагууд төсөв, хяналт, үнэлгээний талаар зохих мэдлэгтэй, хэрэгжүүлэх дадлага чадвартай байх нь төсвийн үйл явцад хяналт тавих боломжтой болох ба төсвийн харилцааны шинэчлэл, төсвийн төрөл онцлогоос хамааран мэдлэг ур чадвараа тасралтгүй сайжруулж байх шаардлага байсаар байна. Үүний тулд энэхүү ГАРЫН АВЛАГА-ыг боловсруулан хүргэж байна.

Тус гарын авлага нь дараах бүтэцтэй. Үүнд:

Бүлэг 1-ээр төсөв, төсвийн бүрэлдэхүүн, төсвийн үе шат, цаглабар болон төсвийн мэдээллийн төрөл, эх сурвалжуудыг танилцуулна.

Бүлэг 2-т оролцоот төсөв, төсвийн оролцооны зарчмын талаар болоод төсвийн үйл явц дах оролцогч талууд, ялангуяа, иргэний нийгмийн оролцооны мөн чанар, ач холбогдлын тухай авч үзнэ.

Бүлэг 3-аар төсвийн мэдээ, мэдээллийн задлан шинжилгээ, төсвийн үйл явцад хийх хяналт, төсвийн шинжилгээ, хяналтын үр дүнг хууль тогтоогчид, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад болоод олон нийтэд түгээх энгийн, хялбаршуулсан арга зүй, аргачлалыг санал болгоно. Мөн бусад улс орнуудын туршлагаас танилцуулна.

Төгсгөлд нь төсвийн шинжилгээ, хяналтын талаарх мэдээлэл бүхий цахим хуудаснууд болоод хэвлэмэл материалуудын жагсаалтыг танилцуулна.

БҮЛЭГ 1:

Төсөв, төсвийн мэдээлэл

Төсөв, төсвийн мэдээ, мэдээлэл ойлгоход төвөгтэй олон тоог илэрхийлсэн, төсвийн шинжилгээ, хяналт хийх нь мэргэжлийн бус хүмүүсийн хийх ажил биш мэт сэтгэгдэл төрж магадгүй. Гэхдээ бодит байдал дээр төсвийг ойлгоход их энгийн хялбар. Төсвийн зарим мэдээллийг ойлгох, ашиглахад мэргэжлийн ур чадвар шаардах ч ихэнхдээ бид өөрт хэрэгтэй, нийгэм, олон нийтийн сонирхлыг татахуйц тоо мэдээлэл, өгүүлэмжийг л тэр дундаас эрж, хайн сонирхдог гэдгийг мартаж болохгүй. Төсвийн энгийн тооцоолол ашигласнаар Та болон танай байгууллага төр засаг амласан амлалтаа биелүүлж байгаа эсэх, татвар төлөгчдийн мөнгө үр ашигтай зарцуулагдаж байгаа эсэхийг төсвөөр дамжуулан үнэлэх бүрэн боломжтой.

Хэн ч төсөвт шинжилгээ хийж чадна – тэдэнд зөвхөн энгийн аргачлал, ойлгомжтой, зөв удирдамж хэрэгтэй. Гэхдээ төсвийн үйл явцад оролцох, үр дүнтэй сурталчилгаа хийх нь тэвчээр, хүлээцтэй байдлыг шаарддаг гэдгийг нөгөө талаас мартаж болохгүй. Мөн төсвийн зөв мэдээллийг олж авах нь хэцүү байж ч магадгүй. Гагцхүү төсвийн үйл явцад оролцох оролцоогоо тууштай байлгаж, урт хугацаанд илүү их амжилт олж болно гэдгийг үргэлж санаж байх нь чухал юм.

1.1 ТӨСВИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТӨСВИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Төр өөрийн чиг үүрэг, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр бий болгох зорилгоор тухайн төсвийн жилд хуримтлуулан хуваарилж, зарцуулах мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын төлөвлөгөөг **ТӨСӨВ** гэнэ.

Тухайн улсын хууль тогтоомжийн дагуу улсын болон орон



нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг **ТӨСВИЙН ОРЛОГО**¹ гэнэ. Төсвийн орлого нь татварын ба татварын бус орлого, тусламжаас бүрддэг.



Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвөөс хуваарилан зарцуулах хөрөнгийг **ТӨСВИЙН ЗАРЛАГА** гэнэ. Төсвийн зарлага нь урсгал болон хөрөнгийн зардлаас бүрдэнэ. Төсвийн зарлага нь төрөөс иргэдэд боловсрол олгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, улс орны аюулгүй байдлыг хангах, дэд бүтцийг хөгжүүлэх, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх зэрэг төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулагддаг.




Тухайн төсвийн жилийн орлого, зарлагын зөрүүг **ТӨСВИЙН ТЭНЦЭЛ** гэнэ. Төсвийн зарлагаас давсан орлогыг **ТӨСВИЙН АШИГ**, орлогоос давсан зарлагыг **ТӨСВИЙН АЛДАГДАЛ** гэнэ. Төсвийн ашиг ба алдагдлыг Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар илэрхийлэх бөгөөд төсвийн алдагдлыг Засгийн газрын бонд, гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлдэг бол төсвийн ашгийг ирэх жилийн төсвийн эх үүсвэрт зарцуулдаг.



Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн дагуу төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэр бий болгох зорилгоор тухайн төсвийн жилд төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах мөнгөн хөрөнгийн орлого зарлагын төлөвлөгөөг **МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ** гэнэ.

1 Монгол Улсын Төсвийн тухай хууль.




1.2 ТӨСВИЙН МӨЧЛӨГ, ЦАГЛАБАР

Төсөв нь боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд үнэлгээ хийх гэсэн дөрвөн үе шат бүхий гурван жил дамнасан тасралтгүй үйл ажиллагаа юм. Төсвийн үе шат бүрд төсвийн баримт бичиг боловсруулагддаг.



Эх сурвалж: Монгол Улсын Сангийн яам, 2019. "Иргэдийн төсөв-2018: Монгол Улсын батлагдсан төсөв"

Төсөв боловсруулах, батлахад төсвийн бүх байгууллага оролцдог. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд **ТӨСВИЙН ЦАГЛАБАР**-ыг нарийвчлан заасан байдаг.



Эх сурвалж: Монгол Улсын Сангийн яам, 2019. "Иргэдийн төсөв-2018: Монгол Улсын батлагдсан төсөв"

1.3 ТӨСВИЙН ҮНДСЭН БАРИМТ БИЧИГ, ТАЙЛАН

Төсвийн мэдээ, мэдээллийг агуулсан үндсэн найман баримт бичиг байдаг: i) төсвийн хүрээний мэдэгдэл, ii) төсвийн төсөл, iii) батлагдсан төсөв, iv) иргэдийн төсөв, v) жилийн явцын тайлангууд, vi) хагас жилийн тойм, vii) жилийн эцсийн тайлан, viii) аудитын тайлан. Эдгээр найман баримт бичиг дэх мэдээлэл нь иргэд, ИНБ-ууд төсвийн төсөл, түүнийг хэрхэн хэрэгжүүлж байгааг ойлгоход туслана. ИНБ-ууд ихэвчлэн төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн явцын тайлангууд болон хагас жилийн тоймыг илүү хязгаарлагдмал байдлаар ашигладаг. Учир нь Засгийн газрууд төсвийн үндсэн 8 баримт бичгийн ихэнхийг хэвлэн нийтэлдэггүй, эсвэл нийтлэгдсэн мэдээлэл дутуу байдгаас иргэний нийгмийн ашиглах боломжийг хязгаарладаг. Жишээлбэл, Монгол Улсын хувьд эдгээр 8 баримт бичгийн нийтэлсэн байдлыг ОУТТ-ээс хоёр жил тутамд явуулдаг “Нээлттэй төсөв” судалгааны тайланд нэгтгэснээр Хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1: Монгол Улс: Төсвийн үндсэн баримт бичгүүдийг нийтэлсэн байдал

Баримт бичиг	2006	2008	2010	2012	2015	2017	2019
Төсвийн хүрээний мэдэгдэл	●	●	●	●	●	●	●
Гүйцэтгэх засаглалын төсвийн төсөл	●	●	●	●	●	●	●
Батлагдсан төсөв	●	●	●	●	●	●	●
Иргэдийн төсөв	●	●	●	●	●	●	●
Жилийн явцын тайлангууд	●	●	●	●	●	●	●
Хагас жилийн тойм	●	●	●	●	●	●	●
Жилийн эцсийн тайлан	●	●	●	●	●	●	●
Аудитын тайлан	●	●	●	●	●	●	●

● Боловсруулаагүй ● Дотоод хэрэгцээнд/хожуу нийтэлсэн ● Нийтэлсэн

Эх сурвалж: ОУТТ, 2015, 2019. “Нээлттэй төсөв”-ийн судалгааны 2015, 2019 оны тайлан

ОУТТ-ээс эдгээр найман баримт бичгийн ач холбогдол, гол агуулга, хэвлэн нийтлэгдсэн байвал зохих хугацааны талаар засгийн газруудад зөвлөсөн байдаг. Энэхүү мэдээллийг Хүснэгт 2-оор танилцуулъя.

Хүснэгт 2: Төсвийн баримт бичгүүд

Ач холбогдол	Гол агуулга	Хэвлэн нийтлэгдсэн байвал зохих хугацаа
ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ		
<ul style="list-style-type: none"> - Бодлого болон төсвийн хуваарилалтын хоорондох холбоог хүчирхэгжүүлэх - Засгийн газрын баримтлах үндсэн стратегийг дунд хугацаанд тодорхой болгох - Төсөв боловсруулах үйл явцын оновчтой байдлыг сайжруулах - Төсвийн хүлээлтийг тохируулах - Хууль тогтоогчид болон олон нийтэд төсвийн өргөн сэдвээр санал өгөх боломжийг олгох 	<ul style="list-style-type: none"> - Макро эдийн засгийн дунд хугацааны урьдчилсан төсөөлөл - Засгийн газрын дунд хугацааны төсвийн зорилтууд - Салбаруудын төсвийн хуваарилалт - Хүлээгдэж буй татвар, орлогын бүрдэлт - Бодлогын шинэ арга хэмжээний зардал ба тайлбар, үндэслэл 	<ul style="list-style-type: none"> - Өмнөх төсвийн жилийн дөрөв эсвэл тавдугаар сар - Заримдаа өмнөх жилийн дунд хугацааны үнэлгээний хамт (7 дугаар сар) - Гүйцэтгэх засаглалын төсвийн төсөл хэвлэн нийтлэгдэхээс хамгийн багадаа нэг сарын өмнө
ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ		
<ul style="list-style-type: none"> - Эдийн засгийн бодлогын хамгийн чухал хэрэгсэл бөгөөд гүйцэтгэх тэргүүлэх чиглэлүүдийг илэрхийлэх - Иргэдийн татварын ачааллыг тодорхойлох - Хүн амын янз бүрийн бүлгүүдэд очих нөөцийн хуваарилалтыг тодорхойлох - Ирээдүй хойч үеийнхний төлөх өрийг тодорхойлох - Иргэний нийгэм, хууль тогтоогчдод бодлогод нөлөөлөх гол боломж олгох 	<ul style="list-style-type: none"> - Сангийн сайдын төсвийн тухай хэлсэн үг ба төсвийн хураангуй - Орлого, төсөвлөсөн хөрөнгө мөнгө - Макро эдийн засгийн урьдчилсан төсөөлөл - Одоогийн бодлогын тогтвортой байдлын үнэлгээ - Орлогын урьдчилсан тооцоолол, тайлбар - Зарлагын тооцоолол, ангилал - Төсвийн алдагдлын санхүүжилт - Өрийн бүрэлдэхүүн - Төсвийн бусад үйл ажиллагаа (жишээ нь нийгмийн хамгаалал) - Санхүүгийн байдлын тухай танилцуулга 	<ul style="list-style-type: none"> - Төсвийн жил эхлэхээс ядаж 3 сарын өмнө

БАТЛАГДСАН ТӨСӨВ

<ul style="list-style-type: none"> - Төсвийн бодит үр дүнг харьцуулж болохуйц суурь мэдээллийг өгдөг - Төсвийн төсөлд хууль тогтоох байгууллагаас оруулсан өөрчлөлтийг үнэлэх боломжийг олгодог 	<ul style="list-style-type: none"> - Томоохон зарлага, орлогын жагсаалт, тэдгээрийн товч тайлбар - Санхүүгийн бус гүйцэтгэлийн мэдээлэл - Төсвийн төсөл болон батлагдсан төсөв хоорондын зөрүү - Өрийн байдал - Эдийн засгийн төлөвийн засварлагдсан мэдээлэл - Засгийн газрын санхүүгийн хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөр дэх нөлөөлөл 	<ul style="list-style-type: none"> - Хууль тогтоох байгууллагаар төсөв батлагдсан даруйд аль болох хурдан буюу төсөв батлагдсанаас хойш 3 сараас хэтрэлгүй
---	--	---

ИРГЭДИЙН ТӨСӨВ

<ul style="list-style-type: none"> - Төсөв бол техник ур чадвар шаардсан, ойлгоход хэцүү - Төсвийн мэдээллийг хүртээмжтэй болгодог - Төсвийн тэргүүлэх чиглэлүүдийн талаарх өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнүүлэх - Засгийн газрын амлалтыг илэрхийлэх ба төр засагт итгэх итгэлийг төлөвшүүлэх 	<ul style="list-style-type: none"> - Баримт бичгийн зорилго, төсвийн үйл явцын танилцуулга, төсвийн хамрах хүрээ - Эдийн засгийн тойм, Засгийн газраас авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсвийн бодлого - Шинэ төсөл, хөтөлбөр, арга хэмжээ - Үйлчилгээг хүргэх арга зам 	<ul style="list-style-type: none"> - Хамааралтай баримт бичгүүдийг хэвлэн нийтлэх ижил цаг хугацаанд
---	---	---

ЖИЛИЙН ЯВЦЫН ТАЙЛАНГУУД

<ul style="list-style-type: none"> - Төсвийн хэрэгжилтийн тойм - Орлого, зарлагын хандлагыг улирлаар тоймлон хүргэх - Төсвийн хэрэгжилтийг нарийвчлан зохицуулахад туслах - Төсвийн удирдлагыг сайжруулах чадавх, тогтолцоог бий болгох 	<ul style="list-style-type: none"> - Төсвийн хэрэгжилтийн ахиц дэвшил - Сар, жил тутамд цуглуулагдсан бодит орлого, зарлага, төлөвлөгөөний харьцуулалт - Засгийн газрын зээлийн үйл ажиллагаа - Төсөвлөгдсөн төсвөөс зөрсөн байдал, эхний илрүүлэлт 	<ul style="list-style-type: none"> - Тайлант хугацааны эцсийн үеэс ядаж нэг сарын дараа (ө.х., 6 дугаар сарын тайлан 7 дугаар сарын 31 гэхэд хэвлэгдсэн байх)
---	---	--

ХАГАС ЖИЛИЙН ТОЙМ

<ul style="list-style-type: none"> - Төсвийн дунд үеийн байдлаарх зарлага, цуглуулагдсан орлого болон анхны тооцоололтой харьцуулсан цогц үнэлгээ хийх боломж олгодог - Макро эдийн засагт гарсан өөрчлөлтийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлэх - Төсвийн хуваарилалтад өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тогтоох, төсвийн тодотгол хийх эсэхийг шийдэх - Тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэхэд гарсан ахиц дэвшлийг үнэлэх 	<ul style="list-style-type: none"> - Эдийн засгийн таамаглалын өөрчлөлт, тэдгээрийн төсвийн тооцоололд үзүүлэх нөлөөлөл - Төсвийн орлого, зарлагын хүлээгдэж буй гүйцэтгэлийн тооцоолол, түүний тайлбар, нотолгоо - Бодлогын өөрчлөлт - Төсвийг танилцуулснаас хойших бодлогын өөрчлөлтүүд ба авч хэрэгжүүлсэн бодлогын шийдвэрүүд 	<ul style="list-style-type: none"> - Тайлант хугацааны эцсээс хойш ядаж 6 долоо хоногийн дараа хэвлэгдсэн байх
---	--	---

ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

<ul style="list-style-type: none"> - Төсвийн жилийн эцсийн байдлаарх зарлага, цуглуулагдсан орлого болон анхны тооцоололтой харьцуулсан цогц үнэлгээ хийх боломж олгодог - Зорилт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр засгийн газрын гүйцэтгэлийг үнэлэх боломж олгодог - Ирээдүйн бодлогын чиглэлийг тодорхойлох боломж олгодог 	<ul style="list-style-type: none"> - Төсвийн ерөнхий үр дүн - Засгийн газрын хөрөнгө, өр төлбөрийн ерөнхий байр суурь (санхүүгийн тайлан) - Эдийн засгийн ангилал, үйл ажиллагааны чиглэлээрх зарлага, өөр өөр ангиллаар цуглуулсан орлогын жагсаалт - Засгийн газрын зарлага, салбараар, хөтөлбөрөөр - Макро эдийн засгийн төсөөлөл болон бодит байдал хоёрын зөрүү, түүний тайлбар - Яам, агентлагуудын гүйцэтгэлийн давуу, сул талууд, тэдгээрийн тайлбар - Зорилт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр засгийн газрын гүйцэтгэлийг үнэлсэн санхүүгийн бус бусад мэдээлэл 	<ul style="list-style-type: none"> - Тайлант хугацааны эцсээс хойш ядаж 6 сарын дараа хэвлэгдсэн байх (ЭЗХАХБ-ын зөвлөснөөр) - Тайлант хугацааны эцсээс хойш ядаж нэг жилийн дараа хэвлэгдсэн байх (ОУВС-ийн зөвлөснөөр)
---	--	--

АУДИТЫН ТАЙЛАН

<ul style="list-style-type: none"> - Төсвийн гүйцэтгэлийн хараат бус, хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээ - Засгийн газар Төсвийн тухай хуулийн дагуу ажилласан эсэх үнэлгээ - Засгийн газрын санхүүгийн тайлангийн үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг үнэлсэн дүгнэлт - Эгэх хариуцлагын өргөх холбооны төгсгөл - Хууль тогтоогчид, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийнхэнд хэрэгтэй Засгийн газрын гүйцэтгэлийн талаарх үнэт мэдээлэл 	<ul style="list-style-type: none"> - Засгийн газрын санхүүгийн тайлангийн үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд өгсөн дүгнэлт - Төрийн санхүүг удирдахад засгийн газрын хяналтын системийн зохистой байдлын талаарх санал - Засгийн газар төсвийн тухай болон бусад холбогдох хуулийг зөрчсөн эсэх тодорхойлолт - Аудитлагдсан санхүүгийн тайлангийн тухай дүгнэлт санал (зөрчилгүй, зөрчилтэй, татгалзсан гэх мэт) - Аудитаар илэрсэн асуудлыг арилгахад чиглэсэн зөвлөмжүүд - Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлтийн байдал 	<ul style="list-style-type: none"> - Төсвийн жилийн эцсээс 6 сарын дотор хэвлэгдсэн байх (ЭЗХАХБ-ын сайн туршлагаар) - Тайлант хугацааны эцсээс нэг жилийн дотор хэвлэгдсэн байх (ОУВС-ийн зөвлөснөөр)
--	--	--

Эх сурвалж: IBP, 2016. "Guide to Transparency in Government Budget Reports: Why are Budget Reports Important, and What Should They Include?"

Дээр дурдсан төсвийн баримт бичгүүдийг болон төсөвтэй холбоотой бусад мэдээллийг дараах эх сурвалжуудаас олж авч болно. Үүнд:

1. Тухайн улсын сангийн яам, холбогдох агентлагийн албан ёсны цахим хуудас (Жишээ нь, Монгол Улсын хувьд www.mof.gov.mn , www.iltod.mof.gov.mn)
2. Тухайн улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (Жишээ нь, Монгол Улсын хувьд www.legalinfo.mn)
3. Тухайн улсын албан ёсны статистик мэдээллийн цахим хуудас (Жишээ нь, Монгол Улсын хувьд www.1212.mn)
4. Төсөв, санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын цахим хуудас (Жишээ нь, Монгол Улсын хувьд "Иргэд төсвөө хянана" иргэний нийгмийн сүлжээний цахим хуудас www.tusuv.mn, www.forum.mn гэх мэт)
5. Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл (телевиз, радио, өдөр тутмын сонин, сэтгүүл гэх мэт)

6. Төрийн, төрийн бус, судалгаа шинжилгээний байгууллагууд, мэргэжлийн холбоод, төсөв санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагаас эрхлэн гаргадаг албан ёсны хэвлэмэл материалууд (тайлан, сэтгүүл, өгүүлэл, нийтлэл, цуврал, брошюр, эмхэтгэл, инфографик мэдээлэл гэх мэт)
7. Төрийн, төрийн бус, судалгаа шинжилгээний байгууллагууд, мэргэжлийн холбоод, төсөв санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагаас зохион байгуулж буй нэгдсэн арга хэмжээ (эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, нийтийн сонсгол, зөвлөлдөх уулзалт, мэтгэлцээн, нээлттэй хаалганы өдөр гэх мэт)
8. Нээлттэй өгөгдөл

Төсвийн мэдээллийг нээлттэй цахим хэлбэрээр олон нийтэд нээлттэй болгох нь иргэд, ИНБ-уудад төсвийн дүн шинжилгээ хийх, хянах, үнэлэх, оролцох үнэ цэнэтэй эх сурвалж болдог. Төсвийн нээлттэй өгөгдөл нь олон нийтэд төсвийн үйл явц, бодлого боловсруулалтыг ойлгож, оролцох, шинэ, шинэлэг өнцгөөс хувь нэмэр оруулах боломжийг мөн олгоно.

Нээлттэй өгөгдөл нь хэлбэр, шинж чанарын хувьд минимум стандартыг хангасан байх ёстой бөгөөд энэ нь өгөгдлийг хэн, ямар хэлбэрээр ашиглаж болохыг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Өргөн хүрээний хэрэглээнд нийцтэй байдлыг хангахын тулд нээлттэй өгөгдөл нь хэрэглэгчдэд янз бүрийн өгөгдлийн багц хоорондын холболтыг харьцуулах, нэгтгэх, дагах боломжийг олгох ёстой. Нээлттэй өгөгдлийн минимум шаардлага гэдэг бол:

- Машин дээр уншигдах боломжтой, интернетэд нээлттэй хэлбэрээр байх;
- Задаргаа сайн буюу ангилсан, засварлах боломжтой, дахин ашиглах боломжтой, харьцуулах боломжтой, хоорондоо ажиллах боломжтой байх;
- Бөөнөөр татаж авах боломжтой бөгөөд судалгаа, шинжилгээнд ашиглах боломжтой байх;
- Мэдээллийн эх сурвалж, хэвлэгдсэн огноо, оюуны өмчийн эрхийн талаарх мэдээллийг хавсаргасан байх;
- Зохио хувилбарыг хянах замаар урт хугацаанд (түүхэн өгөгдөл) хадгалагддаг байх.

Жишээлбэл, АНУ-ын холбооны засгийн газрын төсвийн бүх мэдээлэл нээлттэй хэлбэрээр www.usaspending.gov цахим хуудаст байршсан байна².

Төсвийн асуудлаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, дүн шинжилгээ хийх, хянах, мэтгэлцэх ур чадварыг сайжруулах, боломжийг бүрдүүлэхийн тулд төсвийн нээлттэй өгөгдөлд нэвтрэх нь нэн чухал. Хандалтын саадыг бууруулах нь өгөгдлийг хэрхэн танилцуулж байгаагаас хамаарна. Төсвийн бүх өгөгдөл "анхдагч байдлаар нээлттэй" байх ёстой бөгөөд ингэснээр өгөгдлийг нягт нямбай, хариуцлага тооцох, олон нийтийн хэлэлцүүлгийн зорилгоор ашиглах боломж бүрдэнэ. Төсвийн нээлттэй өгөгдөл нь:

- Нэвтрэх хураамжгүй эсвэл бүртгүүлэх шаардлагагүй чөлөөтэй авах боломжтой байх;
- Хэрэглэгчийн тодорхойлсон динамик асуулга хийх боломжийг олгодог нэг нэгдсэн портал дээр байдаг байх;
- Олон нийтийн оролцоог хангахын тулд тогтмол, цаг хугацаанд нь хангаж өгдөг байх;
- Өгөгдлөөс хамгийн их үнэ цэнийг олж авах, ашиглахад туслах зорилгоор өгөгдөл дүрслэх хэрэгсэлтэй холбогдсон байх.

Жишээлбэл, Боливи улсын Сангийн яам нь төсвийн нээлттэй мэдээллийн систем (SIGMA - Sistema Integrado de Gestión y Modernización Administrativa)-ийг 2000 оноос хойш санал болгосон бөгөөд төсвийн дэлгэрэнгүй мэдээллийг нийтэлдэг. Уг цахим хуудас нь янз бүрийн форматаар татаж авах, түүхэн өгөгдлийг оруулах боломжийг олгодог¹.

Төсвийн нээлттэй мэдээллийн порталуудыг одоо байгаа порталуудтай нэгтгэж, одоогийн мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэх нь өгөгдлийн хүртээмж, нөлөөллийг өргөжүүлдэг. Нээлттэй мэдээллийн портал нь:

1. Нууцлалын болон өгөгдөл хамгаалах хуулийн дагуу хамгаалагдсан байх; Нээлттэй мэдээллийн портал дээр байгаа үндсэн мэдээллийн тайлбарыг агуулсан санхүүгийн удирдлагын мэдээллийн системээс өгөгдлүүдийг шууд нийтэлсэн байх, мета өгөгдөл, үгсийн санг

2 <https://www.oecd.org/governance/budget-transparency-toolkit/applying-transparency/openness-and-civic-engagement/section-i-using-open-data/>

ашиглан олон улсын харьцуулалт хийх боломжийг олгодог байх ёстой.

Жишээлбэл, *Бразил улсын Сангийн яамны цахим хуудас нь мэдээллийн төвлөрсөн эх сурвалж болдог. Энэ нь санхүүгийн удирдлагын мэдээллийн системээс нийтэлдэг бөгөөд "Төлөвлөлт, төсвийн нэгдсэн систем", "Төсвийн гүйцэтгэлийн тайлан" гэх мэт олон нийтийн санхүүгийн цахим хуудасны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, холбоосыг өгдөг. Мөн "Иргэний мэдээллийн үйлчилгээ", "Ил тод байдлын портал", "Нийтийн мөнгөнд ухаалаг хандах" зэрэг хөтөлбөрийн мэдээллийг агуулах бөгөөд ингэснээр төсвийн мэдээллийн хүртээмжийг бий болгож, олон нийтийн оролцоог дэмждэг байна³.*

Монгол Улсын хувьд Сангийн яам нь www.iltod.mof.gov.mn/opendata хуудаст төсвийн мэдээллийн санг байршуулсан байдаг.

БҮЛЭГ 2.

Төсвийн үйл явц дахь ИНБ-ын оролцоо

Төсөв нь мэргэжлийн, улс төрийн, иргэдийн зэрэг олон талт, хамтын, оролцоо шаардсан үйл ажиллагаа юм. Төсвийн үйл явц буюу төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад олон нийтийн оролцоо асар чухал.

2.1 ОРОЛЦООТ ТӨСӨВ

Олон нийтийн оролцоо гэдэгт иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, аж ахуйн нэгж байгууллагууд болон бусад төрийн бус байгууллагууд татвар, төсвийн орлого, эх үүсвэрийн дахин хуваарилалт, нийтийн хөрөнгө болон өр төлбөрийн удирдлага, зарцуулалтын чиглэлээр төрийн байгууллагатай шууд харилцах харилцааг ойлгоно.

ЭЗХАХБ-аас гаргасан зөвлөмжид төрийн байгууллага, албан тушаалтан, иргэдийн хамтын ажиллагааны үндсэн гурван түвшин байдаг талаар дурдсан байна. Үүнд:

Мэдээлэл солилцо


Энэ төвшинд төрийн байгууллага нь иргэдэд өөрийн шийдвэр, үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэх, эсхүл иргэд төрийн байгууллага, албан тушаалтанд мэдээлэл хүргэхэд чиглэсэн ихэвчлэн нэг талын урсгал бүхий харилцаа үүснэ. Үүнд төрийн байгууллага нь иргэдэд өөрийн шийдвэр, үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэх, иргэдэд төрийн байгууллага, албан тушаалтны мэдээлэл нээлттэй, ил тод байх (цахим хуудас, шилэн данс гэх мэт) хэлбэрүүд хамаарна.

Харилцан зөвлөх

Төрийн байгууллага, албан тушаалтан нь тодорхой салбар чиглэлийн хүрээнд бодлого боловсруулахдаа иргэдийн санал, хүсэлтийг байнга авч байх 2 талт харилцаа энэ төвшинд байна. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн санал, санаачилгыг авахын тулд хангалттай мэдээллээр хангах ёстой. Жишээ нь: хуулийн төслийг нээлттэй байлгаж иргэд олон нийтээс санал авах.

Идэвхтэй оролцоо

Төр иргэн хоорондын 2 талт идэвхитэй харилцаа нь энэ төвшинд хэрэгжинэ. Төрийн бодлого боловсруулах, батлах ажиллагаанд иргэд өөрсдийн бүлэг, холбоогоор дамжуулан идэвхитэй оролцох хэлбэрээр илэрнэ.



Эх сурвалж: Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо ТББ 2016. "Монгол Улсын хүчин төгөлдөр хууль, холбогдох захиргааны хэм хэмжээний актад тусгасан төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагаас иргэдийн оролцоог хангах аливаа зохицуулалтын өнөөгийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээний тайлан

Монгол Улсын Улс төрийн боловсролын академийн судлаачид⁴ иргэний оролцооны дөрвөн хэлбэрийг танилцуулсныг өргөнөөр ашиглаж байна. Үүнд:



МЭДЭЭЛЭЭР ХАНГАХ

Мэдээлэх хэлбэрийн оролцоог төрийн болон өөрөө удирдах байгууллагууд, нийтийн эрхзүйн хуулийн этгээдийн ил тод байдлыг хангах, мэдээлэл хүртээмжтэй, хуулиар нууцад хамааруулснаас бусад мэдээлэл нээлттэй байх, мэдээлэл авах хүсэлтийг шуурхай шийдвэрлэх, шийдвэрлээгүй нөхцөлд гомдол гаргах, сургалт сурталчилгаа таниулга хийх зэрэг арга механизмаар хэрэгжүүлэхээр 68 хуульд зохицуулсан байна.



ЗӨВЛӨДӨХ

Иргэдтэй зөвлөлдөх хэлбэрийн оролцоог хангахын тулд сонгуульд оролцох, санал асуулга явуулах, бодлого, хууль тогтоомжид саналыг гаргахын өмнө иргэдээс саналыг авч шийдвэрлэх, иргэдээс өргөдөл гаргах, олон талт бүтцийн нэгж (хороо, зөвлөл гэх мэт) ажиллуулах зэрэг зохицуулалтыг 30 хуульд тусгасан байна.



ИДЭВХТЭЙ ОРОЛЦОХ

Иргэний идэвхтэй оролцоог хангах хэлбэр нь нийтийн сонсгол, цуглаан, мэргэжилтнүүдийг оролцуулсан ажлын хэсэг, ТББ-уудтай хамтран ажиллах, тэдгээрээр тодорхой ажил үүрэг гүйцэтгүүлэх, олон талт бүтцийн нэгж төлөөллөө оролцуулах (үнэлгээний хороо, бусад) зэргээр 59 хуульд тусгалаа олж хэрэгжиж байна.



ХЯНАЛТЫН

Иргэд, олон нийтээс хяналт үнэлгээ хийх хэлбэр нь хуулийн хэрэгжилтэд хамтран болон дангаар хяналт тавих, хуулийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийх, зөрчил гарсан нөхцөлд өргөдөл гомдол гаргах, нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх зэрэг зохицуулалтаар 46 хуульд тусгагдан хэрэгжиж байна.

Эх сурвалж: Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо ТББ 2016. "Монгол улсын хүчин төгөлдөр хууль, холбогдох захиргааны хэм хэмжээний актад тусгасан төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагаас иргэдийн оролцоог хангах аливаа зохицуулалтын өнөөгийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээ"-ний тайлан

Хавсралтад Хүснэгт А1-ээр Монгол Улсын төсвийн үе шат бүрт төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, ИНБ-уудын хамтран ажиллах түвшинг харуулав.

ОУВС-аас гаргасан "Төсвийн ил тод байдлын стандарт"⁵-д нийтийн оролцоог Засгийн газрын зүгээс иргэдэд хүртээмжтэйгээр төсвийн бодлого, түүний нөлөөний тухай хураангуй мэдээлэл хүргэж, иргэдийг төсвийн хэлэлцүүлэг, зөвлөгөөнд оролцох бололцоогоор хангах хэмээн тодорхойлжээ.

Төсөв, санхүүгийн засаглал, бодлогыг сайжруулахын тулд ТИТБОУС байгууллагаас "**Олон нийтийг татан оролцуулахад баримтлах 10 зарчим**"-ыг гаргаж⁶, улс орнуудын засгийн газруудыг баримтлахыг санал болгожээ. Үүнд:

1. Хүртээмжтэй байдал: Олон нийт санхүүгийн болон бусад холбогдох

4 Улс төрийн боловсролын академи, 2013. "Иргэдийн оролцооны эрхзүйн орчин ба үнэлгээ" Судалгааны тайлан

мэдээллийг бүрэн олж үзэх, ойлгох, хэрэглэх, дамжуулах, хувиргахад хялбар байхаар мэдээллийг нээлттэй форматаар бэлтгэх

2. **Нээлттэй байдал:** Тухайн оролцоо бүрийн зорилгод нийцүүлэн цар хүрээ, бэрхшээл, төсөөлж буй үр дүн, явц, хугацаа, олон нийтийн оролцооноос хүлээж буй бодит үр дүн гэх мэт мэдээллийг иж бүрэн олон нийтэд түгээх
3. **Оролцоог хангасан:** Яс үндэс, арьс өнгө, угсаа гарал, шашин, хүйсийн чиг, хөгжлийн бэрхшээл, нас, анги давхаргын байдал үл харгалзан хувь хүмүүс, эмзэг бүлгийн иргэдийн, өөрөөр хэлбэл, төр засагт дуу хоолой нь сонсогддоггүй, хүрдэггүй оролцогч талуудын оролцоог хангахад идэвх, санаачилга гарган олон арга механизм хэрэглэх
4. **Хувь хүний илэрхийлэлд хүндэтгэлтэй:** Бусдын өмнөөс дуугарч байдаг бүлгүүд байдаг тул эрх ашиг нь шууд хөндөгдөж буй хувь хүн, бүлгүүдэд санаа бодлоо өөрсдийнхөөрөө илэрхийлэхийг зөвшөөрч, дэмжих, мөн тэднийг хүсч сонгосон аргаар татан оролцуулах
5. **Хугацаа олгосон:** Төсөв, бодлогын шатлал бүрд олон нийтийн саналыг авах хугацааг хангалттай төлөвлөх, өөрөөр хэлбэл, тухайн асуудлаар иргэдтэй нэгээс дээш удаа холбогдохоор бодолцож хугацааг тавиу тооцох
6. **Нарийвчилсан:** Гол бодлогын зорилго, хувилбар, сонголт, талуудад үүсэх ашигтай байдал мөн нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөг олон талаас нь хэлэлцэх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд шаардлагатай бүх мэдээллээр хангах
7. **Хуваарилалт:** Хэлэлцэж буй асуудал, бодлогын цар хүрээ, үр дагаварт тэнцвэрт байдлыг хангах янз бүрийн аргыг хэрэглэх
8. **Тогтвортой байдал:** Оролцогч талуудын харилцан мэдлэг хуваалцах, итгэлцэх боломж тогтмол харилцаатай байх үед бүрдэнэ, боломж олдох бүрд олон нийтийн саналыг төсвийн бодлого, хяналтын шийдвэрт тусгаж албажуулах, оролцооны тохиолдол бүрт үнэлгээ өгч цаашид сайжруулахад анхаарах
9. **Тус дэмтэй:** Засаглал, хариуцлагын тогтолцооны үр ашгийг нэмэгдүүлэхэд олон нийт, иргэдийн оролцоо ач тустай байх механизм бий болгох
10. **Өгөөжтэй:** Оролцогч талууд зорилго, хүрэхийг эрмэлзэж буй үр дүн, хэнийг төлөөлж байгаагаа нээлттэй илэрхийлнэ, ингэхдээ оролцоог зохицуулж буй дүрмийг дагах, оролцоог хангаснаар хүрэх үр дүнгийн төлөө хамтрах.

Бүх түвшний төсөв боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хянах үйл явцад иргэд, олон нийтийн идэвхтэй оролцоог хангах “Оролцоот төсөвлөл” (Participatory Budgeting) аргачлал 1992 оноос Бразил улсад туршигдсанаар дэлхий даяар түгээн дэлгэрсэн.

ШИГТГЭЭ 1:

Бразил улсын Порто Алегре хотын “Оролцоот-Төсөв санаачилга”-ын туршлага

1980-аад онд нийгмийн баялгийг шударга хуваарилах, иргэдийн оролцоог нээх, нэмэгдүүлэх, төсвийн үйл ажиллагаанд талуудыг татан оролцуулах асуудал хөндөгдөхөд Бразил дарангуйллын засагтай, дэлхийд орлогын ялгаа хамгийн их, хээл хахуульд идэгдсэн улсуудын нэг байсан. Төсвийн бүх шатны явцад бүх нийтийг татан оролцуулах санаачилга гаргасан Порто Алегре нь (2007 оны байдлаар 1.4 сая хүн амтай) Рио Гранд до Сул мужийн нийслэл, төвийн эрх баригчидтай байнга зөрчилтэй байдаг онцлогтой хот юм. Оролцоот-төсөв санаачилгыг эхлүүлэхэд зүүний үзэл баримтлалтай орон нутгийн засгаас гадна ТББ, нөхөрлөлүүд, иргэдийн холбоод оролцож хамтаар шийдвэр гаргах зарчмыг шаардсан (BANK, 2005). Оролцоот-төсөв нь дээрээс доош, доороос дээш чиглэсэн үйл ажиллагааны прагматик нэгдэл юм, улс төрийн эсвэл оюуны загварчлал биш (Novy, 2005). Порто Алегрегийн энэхүү туршлага институцийн шинэ бүтээл юм. Үндсэн санаа нь иргэд улсын төсвийн мөнгөний хуваарилалтад шууд шийдвэр гаргах замаар орон нутгийн, хотын түвшинд оролцох, мөн бүх түвшинд хянах юм. Оролцоо нь 3 түвшинтэй: хөршүүдийн ассамблей, дүүргийн төлөөлөгчдийн оролцоот зөвлөл, хотын иргэдийн оролцооны Ерөнхий зөвлөл. Бүх түвшинд оролцоо нээлттэй бөгөөд хэн нэгэнд давуу тал олгодоггүй. Орон нутгийн ассамблей нь орон нутгийн төсвийг батлах, татгалзах, түдгэлзэх байдлаар оролцоог хангадаг. Төлөөлөгчид иргэдийн хатуу хяналт дор, нэг жилийн хугацаатай сонгогдож ажилладаг. Хотын түвшинд Оролцоот төсвийнхөн жилийн туршид, долоо хоног тутам 2 цаг хуралдана. Тэд орон нутгийн төсвийг (а) “нэг хүн, нэг санал” зарчмаар орон нутгийн хэрэгцээг хангах талаасаа хэрхэн эрэмбэлэгдсэн; (b) оршин суугчдын тоо; (c) дэд бүтцийн чанар эсвэл боломжит үйлчилгээ гэсэн шалгуураар хуваарилна. Оролцоот төсөв төсөл нь улс төрөөс гадуурхагдсан иргэдэд, нийгмийн доод давхаргынханд шийдвэр гаргалтад оролцох бололцоо нээж өгсөн. Оролцоот төсөв төсөл нь төрийн захиргааг өөрчлөн байгуулах хөшүүрэг болсон. Оролцоот төсвийн зөвлөлүүдтэй зөвшилцөлд хүрэхэд төлөвлөлтийг маш сайн хийх шаардлага тулгарсан, төсвийн шинэ аргачлал бий болов. Оролцоот төсөв нь хөрөнгө оруулалтыг жилийн хугацаанд тооцож хэлцдэг тул урт хугацааны хөрөнгө оруулалт, зардлыг тооцоход доголдолтой өөрөөр суурин газрын бүтээн байгуулалтын төслүүд дээр сул тал ажиглагдсан. Хээл хахууль, клиентелизмын сүлжээг эвдэн засаглалыг сайжруулах ахиц гаргаснаар Порто Алегре анхдагч, үр дүнтэй төсөл болсон.

Улсын санхүү, төсвийн үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах Төсвийн зардлыг мөшгих асуулга (PETS) аргачлал гэж байдаг. Дэлхийн банк

улсын зардлыг мөшгих мониторингийн аргыг дэлхийн 8 улсад туршсан ч Уганда шиг амжилттай хэрэгжсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.

ШИГТГЭЭ 2:

“Улсын зардлыг мөшгих мониторингийн арга (PETS)”-ын сургамж

Мөнгийг дага буюу Улсын зардлыг мөшгих мониторингийн (PETS) аргыг анх 1991-1995 оны хооронд Уганда улсын бага сургуулийн төсвийн цоорхой илрүүлэхэд хэрэглэсэн. Энэхүү туршилтын дүнд мөнгөний урсгалын “цоорхой” 80 хувиас 20 хувь хүрч буужээ. Үүний тулд тэд дүүргийн бага сургуулиудын санхүүгийн мэдээг сонинд тогтмол нийтлэх, олон нийтийг мэдлэгжүүлэх аян зохион байгуулах, оролцогч талуудыг чадавхжуулах янз бүрийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулжээ. Угандагийн туршилтаас, 1-рт санхүүгийн урсгалд онц ач холбогдолгүй бүтэц, схем байгааг илрүүлсэн, 2-рт бага боловсролын байгууллагуудад хуваарилагдаж буй төсөв явсаар хүлээн авагч дээр очихдоо өөр үнийн дүнтэй очдог, үүнийг сургуулийн удирдлагын баг мэддэггүй, өөрөөр хэлбэл, мэдээллийн ил тод байдал дутагдалтай байгааг илрүүлсэн байна.

Дэлхийн банк энэхүү туршилтыг 1996 онд Танзанийн боловсрол, эрүүл мэндийн салбарын “бусад зардал”-ыг мөрдөхөд хэрэглэсэн боловч амжилтгүй болжээ. 2001 онд Танзанид дахин туршсан ч дахин бүтэлгүйтэв. ИНБ-уудыг төсвийг хянах үйл ажиллагаанд татан оролцуулах хоёр удаагийн туршилт амжилтгүй болсон олон шалтгаан дурьдснаас: 1-рт аргачлал буруу байсан, 2-рт санхүүгийн мэдээллийг багцалж, хэт ерөнхий гаргадаг учир мөшгихөд бэрхшээлтэй байсан, 3-рт улсын төсвийг мөрдөх нь төсвийн шинжилгээ хийх чадваргүй ИНБ-уудад нүсэр ажил болсон, 4-рт системийн чадавх бүхэлдээ сул байсан, 5-рт эрх баригчид нь мэдээллийг нийтэд ил тод болгох хүсэлгүй, ил болж буй мэдээлэл нь хагас дутуу учир төсвийн шинжилгээ хийхэд хангалтгүй, 6-рт ИНБ-ууд “хянах” зорилгоо ойлгоогүй, төөрөлдсөн (хахуульд өртсөн), 7-рт эрх баригчид хянах үйл ажиллагаанд оролцож буй иргэдийг айлган сүрдүүлсэн, бодитоор дарамталсан, 8-рт мэдээллийг олонд түгээж чадаагүй, 9-рт Танзанид 2005 онд сонгууль болох байсан тул төв захиргаа орон нутагтай, хандивлагч орнууд төвийн засагтай маргаан үүсгэж харилцаагаа муутгахыг хүсээгүй учир харилцан шаардлага тавиагүй г.м. (Sundet, 2008).

Европын улсууд бүхэлдээ, Эстони, Бельги, Финлянд, Швед, Исланд, Герман, Дани, Португали, Румын зэрэг улс онлайн платформыг өргөнөөр ашиглаж байна.

ШИГТГЭЭ 3:

Швед – E оролцоот төсөв: Туршлага

Шведийн интернэт хэрэглээ Европдоо хамгийн өндөр, мэдээлэл харилцааны технологийн улс төрийн зорилгоор оролцоог хангахад хэрэглэдэг туршлагатай

(Amnå, E., 2005). Тиймээс төсөвт иргэдийг татан оролцуулахдаа E-оролцооны платформыг туршихаар Оребро, Удевала, Ханинг хотуудыг сонгожээ.

Оребро хот: Хотын захиргааны дэргэд хороод байгуулж, иргэдтэй зөвшилцөн амын хөдөлгөөн, хүрээлэн буй орчны асуудлыг анхаарч ажиллах “Ардчилал ба Иргэний нийгэм” сэдэвт төсөл хэрэгжүүлэхээр болжээ. Энэхүү төсөл нь дунд сургуулийн ахлах ангийн сурагчид ганцаараа эсвэл бүлгээрээ нийлэн дээрх асуудлыг шийдвэрлэх төсөл бичиж сургууль дотроо нэг төсөл шалгаруулж хотын захиргаа руу явуулна. Эцэст нь сурагчид сургуулиудаас ирсэн төслүүдэд санал өгөх ба гуравны хоёрын санал авсан төслийг сонгоно. Төсөл бичих үйл явцыг хичээлийн хөтөлбөртэй уяж өгсөн ба сурагчид утсаар эсвэл цахим шуудангаар хотын захиргаатай холбогдож мэдээлэл авах, хоорондоо асуудлыг хэлцэх нөхцөлөөр хангагдсан байв. Дүгнэхэд, сурагчдаас цөөн тооны төслийн санал ирэх, төслийн саналд бус сургуульдаа санал өгөх зэрэг сөрөг үр дагавар байсан. Сонирхолтой нь, төслийн явцад сурагчид мэдээллийн технологийг бараг хэрэглээгүй, харин биечилсэн уулзалтууд хийсэн байна.

Ханинг хот: Тус хотын ардчилсан улс төрийн хүчнээс хотын паркийн асуудлаар шийдвэр гаргах явцад иргэдийг татан оролцуулахаар шийджээ. Иргэдээс 101 төсөл ирснийг бүлэглэн 21 төсөл болгон багцлав. Тэгээд төсөвлөсөн төсвөөс хэтрээгүй төсөв бүхий нэг төслийг шалгаруулахаар тэдгээр төслүүдийг төслийн вэб хуудсан дээр байрлуулжээ. Энэхүү туршлагаас төслийн менежментийн багийн зорилго, үүрэг, ажлын арга барил ихээхэн чухал. Иргэд онлайн платформыг ашиглахад техник чадварын бэрхшээл байхгүй ч тэдний үйлдлийг чиглүүлэх, мэдээллээр хангахад багийн идэвхтэй үйл ажиллагаа хэрэгтэй гэж дүгнэжээ (Styliani, 2010).

Төсвийн үйл явцад зорилтот бүлэг, ялангуяа залуучуудыг татан оролцуулахын тулд тэдний сонирхолд нийцтэй хэлбэрийг тухайлбал, тоглоомын арга, онлайн платформыг ашиглан оролцоог хангахад анхаарч ажиллаж байгаа орнууд цөөнгүй байна. Түүний нэг нь Словак улс байна.

ШИГТГЭЭ 4:

Словак улс – Оролцоот төсвийн аргууд: Туршлага

Төсөвт залуучуудыг татан оролцуулах, дадал олгох зорилгоор төр, орон нутаг, олон нийт хамтран “Ямар ч хоёр хот адилгүй” хөлөгт тоглоомыг бүтээжээ. Энэ тоглоом нь иргэд шийдвэр гаргах явцад оролцох эрхтэй үед хотыг хөгжүүлэхэд, төлөвлөхөд хэрхэн оролцохыг тайлбарлан таниулдаг. Тоглоомын оролцогч тус тусын тулгамдсан асуудал (Уйтай, Бохир, Хэнэггүй, Замын бөглөө, Хичээнгүй) бүхий таван дүүрэгтэй хотын зөвлөлийн гишүүний дүрд хувирч өөрийн хариуцсан дүүргийн асуудлаас гадна хотын бусад дүүргүүдийн асуудлуудтай танилцах, тэдний уялдаа холбоог ойлгох, хотын засаглалыг бүхлээр нь танин мэдэх, асуудлын гаргалгааны хувилбар зохиох гэх мэтээр тоглоно. Энэ тоглоомыг Словакийн Trenčiansky samosprávny kraj хотын албан боловсрол олгодог 16 дунд сургуулийн хичээлийн хөтөлбөрт оруулсан байна.

Мөн төсвийн үр дүнд чиглэсэн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор төслүүдэд 70:30 дүрэм боловсруулжээ. Нийт төслийн төсвийн дүнгийн 30 хувьтай дүйх хэмжээний санхүүжилтийг төслийн санаачлагч (хүн цагаар дүйцүүлэн ажиллах, материалын дэмжлэг эсвэл гадны санхүүгийн эх сурвалж олох г.м) бүрдүүлэх ба үлдсэн 70 хувийг Оролцоот төсвөөс гаргадаг байна.

“Иргэдийн дуу хоолой” онлайн платформ нь төсвийн санал авах, сонгон шалгаруулах үеэр нэг талаас иргэд төслийн саналаа оруулах, нөгөө талаас, хотын захиргаа, улсын холбогдох албан байгууллага, ажилтнууд мэдээллийг хүлээн авах, эрэмбэлэх шалгаруулалтын санал авах үйлдэлтэй. Civita Cente онлайн платформ нь иргэдийн саналыг хотын газрын зураг дээр дүрсээр үзүүлж санал авдаг (Dias, N, Enríquez. S & Júlio. S, 2019)

2.2 ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИНБ-ЫН ОРОЛЦОО

Аливаа улсын хөгжлийн гол зорилго нь төлөвлөлт, тусгайлсан төсөл, хөтөлбөр, төсвөөр дамжуулан иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлэх явдал байдаг. Тийм учраас төсөв бол зөвхөн улсын санхүүгийн тайлан биш юм. Энэ нь улсыг хөгжүүлэхийн тулд байгаа нөөцийг зарцуулах гэсэн засгийн газрын хүсэл эрмэлзлийг илэрхийлдэг. Мөн эдийн засгийн бараг бүх салбар, хүн амд нөлөөлдөг. Төсөв нь жилийн, дунд эсвэл урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтууд (жишээлбэл, Алсын хараа 2050, ТХЗ-ууд гэх мэт)-д хүрэх засгийн газрын янз бүрийн амлалтуудыг санхүүгийн хувьд хөрвүүлэн илэрхийлдэг арга хэрэгсэл юм. Энэ нь мөн эрх баригч улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр биелэгдэх эсэхийг харуулна. Иргэний нийгэм улсын төсвийн тэргүүлэх чиглэлд хяналт тавих нь иргэдэд төрд хариуцлага тооцох боломжийг олгоно.

Засгийн газрын төсөв хуваарилалт, зарцуулалтын тэргүүлэх чиглэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нь ядуу болон хөгжлөөс гадуур орхигдсон хүмүүсийн нэн чухал хэрэгцээг хамарсан оролцооны үйл явц байх ёстой. Хэдийгээр иргэдээс сонгогдсон төлөөлөгчид тэдний хэрэгцээнд нийцсэн тэргүүлэх чиглэлийг хэлэлцэж, шийдвэрлэснээр ардчилсан тогтолцоонд үүрэг гүйцэтгэдэг ч төлөөлүүлж буй хүмүүсийн жинхэнэ бодит оролцоо ихэвчлэн дутмаг байдаг.

Төсөв боловсруулах явцад иргэдийн дуу хоолойг тасалдуулах нь төсөв, төсвийн үйл явцыг задлах, иргэдийн үндсэн хэрэгцээг хангах, төсвийн хуваарилалтыг сайжруулах, санхүүжилт хуваарилах зарчим, санхүүгийн авлигаас урьдчилан сэргийлэх зэрэгт сөрөг нөлөөтэй. Төр, иргэн хоёрыг

холбохын тулд ИНБ-ууд төсвийн дүн шинжилгээ хийх, хянах үйл явцад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх ёстой.

Сүүлийн жилүүдэд улс орнуудын төр засгаас ИНБ-уудыг дэмжиж, засаглалын хөтөлбөрт идэвхтэй оролцох үүрэг, боломжийг нэмэгдүүлэх, төсвийн ил тод байдлыг хангаж, ИНБ болон хууль тогтоох байгууллагуудын бие даасан хяналтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төрийн санхүүгийн шинэ практик туршлагуудыг нэвтрүүлэх, төвлөрлийг сааруулахад ихээхэн анхаарснаар төлөвлөлт, төсөвлөлтийг олон нийтэд ойртуулж, тэдний хувьд илүү бодитой болгож байна.

Төсвийн үйл явц дах олон нийтийн оролцоо, тэр дундаа иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах нь төсвийн ил тод байдал, хариуцлага, үр ашгийг дээшлүүлэх боломжийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэртэй. Олон нийтийн оролцоог хангах арга хэмжээнд хяналтын зөвлөл, хороо, ажлын хэсэг байгуулах, УИХ хэлэлцүүлгийг бүх нийтийн нээлттэй сонсгол хэлбэрээр зохион байгуулах, олон нийтийн санал асуулга явуулах, нээлттэй харилцах утас ажиллуулах, мессежээр санал авах гэх мэт аргуудыг тоочиж болох ба төсвийн аль үе шатад олон нийт оролцож байгаагаас шалтгаалж аль нэг болон хэд хэдэн аргыг сонгон хэрэглэж болно.

Төсвийн үйл явцын үе шат бүрт ИНБ болон иргэний гүйцэтгэх үүрэг дараах байдалтай байна. Үүнд:



Улс орнуудад иргэдийн эрэлт хэрэгцээг төр захиргааны байгууллагад мэдээлэх ИНБ-уудыг оролцуулсан албан ёсны орон зай үргэлжид дутмаг байдаг. Хууль тогтоогчид энэ асуудлаар шүүмжлэлтэй мэтгэлцээн, яриа, хэлэлцүүлэг өрнүүлэх суурь мэдээллээр мөн хангагдаагүй байдаг. Үүний дүнд засгийн газар дангаараа шийдвэр гаргагчийн үүрэг гүйцэтгэж, гүйцэтгэх засаглал нь зардлын тэргүүлэх чиглэлийг дангаараа шийдэхэд хүрдэг. Төсвийн мэдээллийн сан байхгүй, мэдээлэл олж авах боломж хомс, төсвийн асуудлыг хэлэлцэх албан болон албан бус орон зай байхгүй зэргээс ИНБ-уудын үүрэг ихэвчлэн хязгаарлагддаг. Иргэний нийгмийн гол үүрэг гүйцэтгэгч хэвлэл мэдээллийнхэн ч гэсэн төсвийн үр дагаврыг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай мэдлэг чадвараар дутмаг байдаг. Цаг тухайд нь үнэн зөв мэдээлэл дутагдсанаас болж хэвлэл мэдээллийн хэрэгслүүд иргэд, тэр дундаа ядуучуудын амьдралд нөлөөлж буй төсвийн чухал асуудлуудыг олон нийтэд болоод холбогдох талуудад бүрэн гүйцэд хүргэж чаддаггүй.

ИНБ-ууд үүргээ гүйцэтгэхийн тулд эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, улс төрийн нам, хэвлэл мэдээллийнхэн, иргэний хөдөлгөөн, форумуудтай түншлэл, сүлжээ, зөвлөл, холбооны гэх мэт зохион байгуулалтад орж, хамтран ажиллаж болно. ИНБ-ууд бодлого боловсруулалт, төсөвлөлт, төлөвлөлтийн чанарыг дээшлүүлэхийн тулд хууль тогтоогчид болон хэвлэл мэдээллийнхэнтэй тогтмол хэлэлцүүлэг явуулдаг байх хэрэгтэй.

2.3 МОНГОЛ УЛС: ИНБ-УУДЫН ТУРШЛАГА

Өнөөдрийн байдлаар, төсвийн мэдээлэл, холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийн, мэтгэлцээн, хэлэлцүүлэг явуулж, төр засагт мөнгө хэнээс орж ирж, хэнд зарцуулагдаж байгааг ойлгуулах боломжийг хангадаг, хууль тогтоогчдод тодорхой төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн ач холбогдлыг таниулах үйл ажиллагаанд оролцож буй ИНБ-ууд цөөхөн байна.

Нээлттэй нийгэм форум (ННФ): ННФ нь Монгол Улсын төсөв, санхүүгийн асуудлаар тогтмол хэлэлцэн, бодлогын шинжилгээ хийж, үр дүнг цувралаар бодлого боловсруулагчид, мэргэжилтнүүд, олон нийтэд нээлттэй хүргэдэг төрийн бус байгууллага. Анх 2006 онд “Төрийн ил тод байдал: Нийгмийн баялгийн хуваарилалт” форумыг зохион байгуулж, 5 үндсэн сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж байсны нэг нь “Улсын төсвийн ил тод байдал” байв. Мөн 2007 онд ОУТТ-ээс эрхлэн гаргасан “Төсвийн чиглэлээр ажиллах ТББ-уудад зориулсан гарын авлага”-ыг орчуулан олон нийтэд хүргэж байсан.

ШИГТГЭЭ 5: Монгол Улс – Нээлттэй нийгэм форум: Туршлага

ННФ-аас төрийн төсөв, санхүүд тавих хяналтыг сайжруулах, мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх, бодлогын шийдвэрт иргэдийн дуу хоолойг тусгахад дэмжлэг үзүүлэх зорилгоор төсвийн мэргэшсэн мэргэжилтнүүдээс бүрдсэн “Төсвийн зөвлөл”-ийг санаачлан, 2021 оны 3 дугаар сард байгуулсан байна. Төсвийн зөвлөл нь хараат бус шинжээчдээс бүрдсэн бөгөөд иргэд нийтийн төсөв, сан хөмрөгийг удирдахад мэдээлэлтэй оролцох, хяналт тавих боломж нөхцөлийг бүрдүүлэх үндсэн дээр нийтийн сан хөмрөгийн оновчтой зарцуулалтыг дэмжих зорилгыг дэвшүүлэн ажилладаг байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд бие даасан судлаач-эдийн засагч, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, Санхүүгийн хүртээмж-хөгжил ТББ, BFAS санхүүгийн зөвлөх үйлчилгээний компани, Сэргэлт консалтинг групп компани, Банк, санхүүгийн академи, ННФ зэрэг төсөв, санхүүгийн чиглэлээр мэргэшсэн ТББ болоод аж ахуйн нэгжийн төлөөлөл ордог байна. Зөвлөл байгуулагдсанаасаа хойш “Төсвийн гадуурх зарцуулалт” сэдвээр дүн шинжилгээ Монгол Улсын хувьд төсвийн сахилга батыг дээшлүүлэх, бодлогын үр дүнг сайжруулах, төсвөөс гадуурх зарцуулалтыг хязгаарлаж, түүнд тавих хяналтыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа талаар эхний хэлэлцүүлгээ хийжээ. Мөн “Бодлогын асуудал” цувралыг эрхлэн гаргаж, үүгээр дамжуулан төсөв, санхүүгийн чиглэлээр анхаарах асуудлыг олон нийтэд танилцуулж байна. Тухайлбал, 2021 оны цуврал №32-оор “Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд анхаарах асуудал”-ыг танилцуулсан байна. ННФ-аас 2020 оны 10-р сард Монгол Улсын 2020 оны батлагдсан төсөв, төсвийн тодотгол, 2021 оны төсвийн төслийн шинжилгээг Монголын Эдийн засгийн шинжилгээ, судалгааны төв ТББ-ын судлаачдаар хийлгэсэн байна. Энэхүү төсвийн шинжилгээний хүрээнд 2020 болон 2021 онуудын төсвийн баримт бичиг, тооцооллуудад шинжилгээ хийж, цаашлаад эдгээр оны төсвийн төсөөллийг эдийн засгийн бусад үзүүлэлттэй нийцүүлэн боловсруулжээ.

Үүнээс хойш улсын төсвийн ил тод байдлыг хангуулах хүрээнд ТББ-ын мониторинг тэтгэлэгт хөтөлбөрөөр дамжуулан улс, орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, батлагдсан төсөв, төсвийн тодотгол, төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэж байна. Энэхүү мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрөөр дамжуулан ТББ-уудын төсөв, санхүүгийн чиглэлээр ажиллах чадавхыг сайжруулахын зэрэгцээ сэдэвчилсэн сургалтуудыг мөн ТББ-уудын дунд зохион байгуулж байна.


“Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээ: Төсөв, санхүү, худалдан авах авалтын хяналт, мониторингийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд нэгдэж, ННФ-ын дэмжлэгтэйгээр “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээг 2009 онд байгуулсан байна. Сүлжээнд Ардчиллын боловсрол төв, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, Захиргааны шинэ санаачлага, Зориг сан, Зохистой хөгжлийн жендэр төв, Иргэний

боловсрол төв, Иргэний холбоо, Мэдээлэл, олон нийтийн харилцааны инфорум төв, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн, Нээлттэй нийгэм форум, Орон нутгийн удирдлагын хөгжлийн сан, Хүний эрх хөгжил төв зэрэг иргэний нийгмийн байгууллагууд гишүүнчлэлтэй. Мөн Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM), Зөв тусгал, Ил тод байдал сан, Монголчууд шударга татвар, ухаалаг зардлын төлөө ТББ-ууд болон Инфратест судалгааны төв, Иргэдийн санал судлал, хөгжлийн төв зэрэг нь түншлэгч байгууллагаар хамтран ажилладаг байна.

Уг сүлжээ нь эхэндээ УИХ-ийн гишүүдийн тойргийн мөнгө, улсын төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авалтад мониторинг хийдэг байснаа сүүлдээ орон нутгийн төсвийн үйл явц, тухайлбал, ОНХС-ийн хэлэлцүүлэг үндсэн үйл ажиллагаа нь болсон.

ШИГТГЭЭ 6: Монгол Улс – “Иргэд төсвөө хянана” ИНС: Туршлага

Сүүлийн жилүүдэд төрийн болон төсвийн байгууллагуудын шилэн дансны хэрэгжилтэд ихээхэн анхааран ажиллаж байгаа аж. Тус сүлжээнээс орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын индекс судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2011, 2013, 2016 онд гүйцэтгэсэн байна. Түүнчлэн, 2015 оноос хойш орон нутгийн төсвийн мониторинг, улсын болон нийслэлийн төсвийн онцлох зарцуулалт, хөрөнгө оруулалтын талаар дүн шинжилгээ хийсэн. Сүлжээгээр дамжин хийгдсэн бүх төрлийн судалгаа шинжилгээ, мониторингийн тайлан, товч мэдээллийг www.tusuv.mn цахим хуудсаар дамжуулан нийтэд хүргэдэг. Уг цахим хуудас нь Монгол Улсын төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн мэдээллийг “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээний мониторингийн явцад ил тод, нээлттэй болгож, үнэлэлт дүгнэлт өгөхийн зэрэгцээ олон нийтийн ой санамж болгон хадгалж буй сайт ажээ. Тус сайтад төсвийн анхаарал татсан онцлох асуудлаарх цаг үеийн мэдээллийг цуглуулж, боловсруулан нийтэлдэг, мөн “Шилэн дансны ажиглалт”, “Орон нутгийн төсвийн ил тод байдал” гэсэн дэд сайтуудтай. Мөн тус сүлжээнээс “Төсвийн ажиглалт” сонин бичгийг эрхлэн гаргаж, 2 удаагийн цувралыг олны хүртээл болгожээ.



Захиргааны шинэ санаачлага ТББ: Шилэн түрүүвчний аянаас үйл ажиллагаа нь эхэлсэн “Захиргааны шинэ санаачилга” ТББ 2008 онд байгуулагдсан. Төрийн болон ТББ-ын захиргааны шинэтгэлийг дэмжих эрчимжүүлэх чиглэлээр ажилладаг. “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээ, “Төлсөн авснаа нийтэл” эвслийн гишүүн, “Ил тод байдлыг дэмжих түншлэл”-ийн гишүүн, “Хөгжлийн ажиглагч” ННФ-ын гишүүн байгууллага. Үйл ажиллагааны чиглэл нь төсөв ил тод байх, оролцоотой байх, хяналттай байх бүхий түвшинд хүрч ажиллахыг зорьдог, өнгөрсөн хугацаанд тодорхой үр дүнд хүрсэн. Тус байгууллага нь олон нийтийн санаачилгыг өрнүүлэх замаар төрийн болон орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагуудтай хамтран ажиллаж төрийн нээлттэй, ил тод, хэрэглэгч төвтэй үйлчилгээг сайжруулахад нөлөөллийн гол үүргийг гүйцэтгэж байна. Тэд шилэн дансны мэдээллийг мөшгөх замаар хяналт хийдэг. Шилэн данснаас илрүүлсэн асуудлаа хэрхэн шийдвэрлэх талаар шийдэл, арга зам, арга хэрэгслийг боловсруулж, тэдгээрийг шийдвэр гаргагчдад албан журмаар хүргүүлж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг иргэдэд түгээдэг байнгын идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Үйл ажиллагааныхаа үр дүнг анимэшн, гарын авлага, ном сурах бичиг, хурал зөвлөгөөний тайлан мэдээгээр олон нийтэд хүргэдэг байна. Түүнчлэн, зарим дүүрэг, аймгийн ИТХ-ын дэргэд иргэний хяналтын зөвлөл байгуулан, тэдгээр хүмүүст хяналт хийх сургалт явуулан, сургалтын дагуу төсвийн зарцуулалтад хяналт хийх замаар хамтран ажилладаг. Төсвийн хяналт, шинжилгээ хийхэд ашиглагдах гарын авлага, тараах материалыг бэлтгэн ашиглаж байна (Хавсралтаас тараах материалыг харна уу). Төлөөллийн байгууллагын хяналтын чиг үүргийг чадавхжуулах чиглэлийн хүрээнд “Иргэд төсвөө хянана” гарын авлагыг 2018, 2019, 2020 онд гаргасан байна.

БҮЛЭГ 3.

Төсвийн гүйцэтгэлд хяналт, шинжилгээ хийх аргачлал

Төсвийн хуваарилалт, зарцуулалт нь зөвхөн санхүүгийн тайлан мэдээлэл биш бөгөөд төсөв нь хүмүүсийн амьдралд чухал нөлөө үзүүлдэг. Төсөв боловсруулагчид энэ талаар төдийлөн сайн мэдээ, мэдээлэлтэй байдаггүй. Ийм учраас тэдэнд ойлгуулахын тулд бүхий л талуудад тухайлбал, засгийн газар, яам, агентлаг, хууль тогтоох байгууллагын гишүүд, байнгын хороодын гишүүд, албан тушаалтнуудад маш их хэмжээний задлан шинжлэн, нэгтгэн дүгнэсэн төсвийн мэдээлэл тараах хэрэгтэй болдог. Төсвийн шинжилгээний үр дүн, дүгнэлтийг мөн хэвлэл мэдээллийнхэн, эрдэмтэн судлаачид, ИНБ-ууд, иргэдэд хүргэх хэрэгтэй.

3.1 ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ АРГА ЗҮЙ



Төсвийн шинжилгээ гэж юу вэ?

Энэ нь санхүүгийн жилийн эхэнд төсөвлөгдсөн төсвийн хуваарилалтыг ажил хэрэгчээр шүүмжлэн үнэлэх, төсвийн хуваарилалтын дагуу зарцуулалт хийгдсэн эсэхийг хянах арга хэрэгсэл юм. Төсвийн шинжилгээ нь төсөв улсын бодлогын тэргүүлэх чиглэлүүдэд хуваарилагдсан эсэх, төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд хангалттай эсэх, төсвийн хэмжээ өсөж, буурч буй эсэх, төсөв алдагдалтай буюу орлого, зарлага тэнцэж буй эсэхийг тодорхойлох боломжийг олгодог.

Төсвийн шинжилгээг мэргэшсэн төсөв, санхүүгийн мэргэжилтнүүд төвөггүйхэн хийчихнэ. Харин төсвийн үйл явцад идэвхтэй оролцдог эсвэл оролцохыг хүсдэг иргэний нийгмийнхэн тэр бүр төсвийн шинжилгээний арга зүй эзэмшээгүй байдаг. Иймд тэд төсвийн шинжилгээний зорилго, арга

зүй, алхмыг мэдсэнээр маш энгийн хялбархнаар төсөвт шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт гарган, олон нийтийн анхаарлыг төсөв хандуулах, засгийн газрын үйл ажиллагааг дүгнэх өргөн боломжтой болно.



Төсвийн шинжилгээ ямар зорилгоор хийдэг вэ?

- Төсвийн хуваарилалт, бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн дүн шинжилгээ хийхэд туслах. Ихэнх тохиолдолд төсвийн хуваарилалт нь засгийн газрын тэргүүлэх чиглэлтэй нийцдэггүй.
- Төсвийн хуваарилалт нь иргэдийн өдөр тутмын амьдралд хэрхэн нөлөөлж байгааг мэдээлэх, төсвийн хуваарилалтыг илүү тэгш байлгахын тулд олон нийтийн санаа бодлыг идэвхжүүлэхэд туслах
- Мэдээлэл солилцох, олон нийтийн төсвийн талаарх ойлголтыг сайжруулах
- Төсвийн хуваарилалтын зарим салбарыг онцгойлсон байдлын талаар хэлэлцүүлэг өрнүүлэх. Төсвийн шинжилгээ нь төсвийн зарлагын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хомс нөөцийг оновчтой ашиглахад тусална.
- Орлогын бодлогыг олон нийтэд мэдээлэх. Татвар, татварын шинэчлэлийн янз бүрийн нөлөөллийг шинжлэх замаар нийгмийн бүлгүүдийн тэгш байдлыг хангахад тусална.
- Төсвийн хуваарилалтад нөлөөлөх. Төсвийн дүн шинжилгээ нь санхүүжилтийн цоорхойг тодорхойлсноор зарим салбарын төсвийг нэмэгдүүлэх эсвэл өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай эсэхийг тодорхойлоход тусална.
- Эмэгтэйчүүд, хүүхдүүд, залуучууд гэх мэт нийгмийн эмзэг бүлэгт зориулагдсан хөрөнгийн зорилтот түвшнийг нэмэгдүүлэхэд туслах
- Төсвийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, илүү өргөн мэдээлэл солилцоход туслах. Мөн төсвийн хуваарилалт нь тэдний өдөр тутмын амьдралд хэрхэн нөлөөлж байгааг иргэдэд ойлгуулах.
- Төсвийн хуваарилалтын зарим салбарт үзүүлэх үр дагаврын талаарх хэлэлцүүлгийг эхлүүлэхэд туслах. Төсвийн хуваарилалтад шинжилгээ хийснээр төсвийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой болдог.



Төсвийн шинжилгээнээс бид юу мэдэж авах вэ?

- **Хангалттай байдал:** Хэр ихийг төсөвлөсөн бэ? Төсвийн хуваарилалт (тодорхой салбарт зориулагдсан) бодлогын зорилтыг биелүүлэхэд хангалттай юу? Зарим эмзэг бүлгийнхний хэрэгцээ шаардлага хангахад чиглэгдсэн салбарын төсвийн хуваарилалт боломжит хөрөнгө мөнгөнөөс давж магадгүй. Тэгвэл төсвийн хуваарилалтын дүн шинжилгээ нь засгийн газар эдгээр шаардлагыг хангахын тулд зохих арга хэмжээ авч чадах эсэхийг тодорхойлоход тусална.
- **Тэргүүлэх чиглэл:** Нийгмийн тодорхой салбар/халамжид зориулагдсан төсвийн хуваарилалтыг бусад салбарт хуваарилсан нөөцтэй яаж харьцуулах вэ?
 - Төсөв тусгагдсан засгийн газрын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;
 - Бодлогын тэргүүлэх чиглэлүүд төсөвт тусгагдсан тэргүүлэх чиглэлтэй нийцэж буй эсэхийг тодруулах;
 - Засгийн газар амлалтаа биелүүлж буй эсэхийг тодорхойлох.
- **Ахиц дэвшил:** Тухайн асуудлыг сайжруулахад засгийн газар хариу үйлдэл хийсэн үү? Засгийн газрын амлалтыг хянах.
- **Тэгш боломж:** Нөөцийг шударгаар хуваарилсан уу?
 - Нэг хүнд ногдох зардал, газар зүйн байршлаар
 - Нөөцийг үр ашигтай зарцуулж байна уу?
 - Нөөцийг үр дүнтэй зарцуулж байна уу?



Төсвийн шинжилгээний хэдэн төрөл байдаг вэ?

Төсвийн шинжилгээний хэд хэдэн төрөл, олон янзын арга, аргачлал байдаг бөгөөд зорилгоосоо хамааран нэг болон хэд хэдэн аргаар шинжилгээг хийж болно. Гол нь шинжилгээ үнэн зөв, үндэслэлтэй тооцоо мэдээлэлд суурилсан байх нь чухал. Төсвийн шинжилгээ нь төсвийн бодлогын шинжилгээ, салбарын шинжилгээ, төсвийн хуваарилалтын хандлагын шинжилгээ, орлогын шинжилгээ гэсэн нийтлэг төрөлтэй байдаг.

ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨРЛҮҮД



Төсвийн шинжилгээг хэдэн алхмаар гүйцэтгэх вэ?

ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЛХАМ



Хүснэгт 3-т төсвийн шинжилгээ хийх ерөнхий удирдамжийг харуулав.

Хүснэгт 3: Төсвийн шинжилгээ хийх ерөнхий удирдамж

Алхам	Юуг хийх вэ?
Шинжилгээний цар хүрээг шийдэх	Эхний алхам бол шинжилгээний хамраг хүрээг тодорхойлох явдал юм. Жишээлбэл, төсвийн шинжилгээг нийт улсын нэгдсэн төсвийн хүрээнд бус аль нэг салбараар, тухайлбал, боловсролын салбарыг сонгон, түүн дотроо сургуулийн өмнөх боловсролыг сонгох.
Зорилгоо дэвшүүлэх	Дараагийн алхам бол төсвийн шинжилгээний зорилгоо тодорхойлох явдал юм. Зорилго тодорхойлсон зарим жишээг дурдвал: <ul style="list-style-type: none"> - Хүүхдүүдэд зориулсан төсвийн зарлагын илт тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг үнэлэх - Хүүхдүүдэд зориулсан төсвийн хуваарилалтын шинжилгээ хийх
Шинжлэн дүгнэх тусгайлан параметр, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох	Дараагийн алхам бол шинжлэх шалгуур үзүүлэлтүүдийг сонгох явдал юм. Жишээлбэл, хүүхдүүдэд зориулсан төсвийн шинжилгээ хийж байгаа үед: <ul style="list-style-type: none"> - Үндэсний хөгжлийн болоод сангийн бодлогын хүүхдэд ээлтэй байдал - Хүүхдүүдэд зориулсан хөрөнгө оруулалтын хэмжээ - Хүүхдийн эрхийг хангахад зориулсан төсвийн хуваарилалтын хангалттай байдал - Төсвийн зарцуулалтын үр дүнтэй ба үр өгөөжтэй байдал - Иргэд, хүүхдүүдийн төсвийн үйл явц дах оролцооны түвшин гэх мэт
Судалгааны арга зүйгээ сонгох	<ul style="list-style-type: none"> - Энэ шатанд түүврийн стратеги, мэдээлэл цуглуулах арга, хэрэгсэл, шинжилгээний аргаа шийдсэн байна. - Төсвийн шинжилгээ ихэвчлэн тоон судалгааны аргачлалаар хийгддэг. Тоон өгөгдлүүдийг ихэвчлэн хүснэгт, зураг, диаграм, гистограмаар дүрсэлдэг. - Зарим тохиолдолд чанарын судалгааны аргачлалыг ашиглаж болно. Тухайлбал, ил тод нээлттэй байдал, хариуцлага, оролцоо зэргийг хэмжихэд чанарын судалгааны аргууд ихэвчлэн хэрэглэгддэг.
Төсвийн шинжилгээг гүйцэтгэх	<ul style="list-style-type: none"> - Төсвийн шинжилгээг өөрөө эсвэл бусдаар буюу мэргэшсэн шинжээчдээр гүйцэтгүүлж болно. - Тоон өгөгдлийн чанарыг сайтар анхаарах. Аль болох албан ёсны статистик тоо мэдээлэл ашиглах. - Шинжилгээнд хамрагдаж буй хүн амын бүлэг эсвэл салбарын төлөөлөлтэй уулзаж, санал бодлыг сонссон байх - Төсвийн шинжилгээний үр дүнг дэлгэрэнгүй болон хураангуй байдлаар бэлтгэн засгийн газар болон холбогдох талуудад хүргэх, олон нийтийн хүртээл болгож, тэдний анхаарлыг төсвийн асуудалд хандуулах.

Төсвийн хяналт гэж юу вэ?

Төсвийн хяналт нь төсвийн зорилго, зорилт өөрийн үндсэн зарчимд суурилан хэрэгжиж, өөрийн зорилго зорилтдоо хүрсэн эсэхийг үнэлэх үйл явц юм. Төсвийн хяналтын объект нь төсвийн орлого бүрдүүлэлт, зардал санхүүжилтэд холбоотой бүхий л этгээдүүдийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэх, үр дүн байна.

Төсвийн хяналтын зорилго юу вэ?

ИНБ, иргэдийн хяналтын зорилго нь бүх шатны төсвийн зохистой бөгөөд үр ашигтай байдлыг иргэд өөрсдөө үнэлэх үйл явц бөгөөд мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх явдал юм. ИНБ, иргэдийн бүх шатны төсөвт хийх хяналт шалгалтдаа дараах зарчмыг баримталбал зохино.

- Аливаа дүгнэлт баримттай байх ёстой ба үүнийг баримтад заавал хавсаргах шаардлагатай.
- Дүгнэлт нэг мөр, алдаагүй, тодорхой, бодитой байхад анхаарах хэрэгтэй.

Төсвийн үйл явцад ИНБ, иргэдийн хяналт төсвийн үндсэн зарчмууд хэрхэн хангагдаж, түүний үндсэн зорилго хэрхэн хангагдсаныг тодорхойлон, түүнийг сайжруулахад чиглэгдсэн нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

Төсвийн үйл явцад ИНБ, иргэд хяналт хийх дараах шаардлагууд байдаг. Үүнд:

- Эдийн засгийн бодлого хөтөлбөр, нийгэм эдийн засгийн нөхцөл байдалтай уялдаж байгаа эсэх, зайлшгүй шаардлагатай хөтөлбөрүүд тусгагдсан эсэх, санхүүжилт хүрэлцээтэй эсэх;
- Батлагдсан төсөв зориулалтын дагуу, зохистой зарцуулагдсан эсэх;
- Төсвийн хэрэгжилт төсвийн төлөвлөлтийн зорилго, зорилтод хүрсэн эсэхийг үнэлэх.

Төсвийн хяналтын ач холбогдол юу вэ?

ИНБ, иргэд төсвийн үйл явцад хяналт тавьж оролцох нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Төсвийн үйл явцад иргэдийн хувьд тодорхойгүй байгаа асуудлыг тодруулах;

- Төлөвлөлт, гүйцэтгэлийн явцад зөрчил дутагдал анхаарах асуудлыг ил гаргаж тавих;
- Төсвийн үндсэн зарчмууд хангагдсан эсэх;
- Төсвийн эрх мэдлийн хүрээний үүрэг хангагдсан эсэхийг тодорхойлон иргэний оролцоотойгоор хуулийн хүрээнд шийдвэрлэх арга замыг тодорхойлох боломжтой болно.

Төсвийн хяналтын хэдэн хэлбэр байдаг вэ?


Төсвийн үйл явцад хийх хяналт үнэлгээ төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн буюу гүйцэтгэлд үндэслэгдэн дараах дарааллаар хийгдэх нь зохимжтой.

ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ БА ХЯНАЛТЫН ХЭЛБЭРҮҮД



Монгол Улсын төсвийн үйл явцад иргэдийн оролцоо, хяналтын хэлбэрийг тодорхойлбол:

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦАД ИРГЭДИЙН ОРОЛЦОО, ХЯНАЛТЫН ХЭЛБЭР



Иргэний оролцоог хэрэгжүүлэх хэлбэр

Урьдчилсан хяналт шалгалт

- ➔ Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төлөвлөгөөг өмнө жилийн төсвийн гүйцэтгэлтэй харьцуулах
- ➔ Ач холбогдлын зэрэглэлээр эрэмбэлэн санал өгсөн төслүүд төсвийн төсөл тусгагдсан эсэх
- ➔ Төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилт төсвийн эрх мэдлийн хүрээндээ жигд хуваарилагдсан эсэх,

Үйл ажиллагааны хяналт

- ➔ Зардал санхүүжилт хүртээмжтэй байдал
- ➔ Худалдан авалтын мэдээлэл ил тод байдал
- ➔ Тендер шалгаруулалт, гүйцэтгэлийн зохистой байдал

Гүйцэтгэлийн хяналт

- ➔ Бүх шатны төсвийн гүйцэтгэлийн аудитлагдсан тайлантай танилцах
- ➔ УИХ, аймаг хотын ИТХ-аар тайланг хэлэлцэхэд оролцон дүгнэлт өгөх

Иргэний оролцоог хангах баримт бичгүүд

Үндсэн баримт бичгүүд

- ➔ Хөгжлийн хөтөлбөр
- ➔ Төсвийн дунд хүрээний мэдэгдэл
- ➔ Төсвийн төсөл
- ➔ Төсвийн тухай хууль

Үндсэн баримт бичгүүд

- ➔ Төсвийн төсөл
- ➔ Төсвийн тухай хууль

Үндсэн баримт бичгүүд

- ➔ Тухайн оны батлагдсан төсөв
- ➔ Худалдан авалтын төлөвлөгөө
- ➔ ТЭОНӨБАУХА тухай хууль
- ➔ Шилэн дансны тухай хууль

Үндсэн баримт бичгүүд

- ➔ Тухайн оны аудитлагдсан санхүүгийн тайлан
- ➔ Төсвийн зорилго, хэрэгжилтийн тайлан
- ➔ Өмнө боловсруулсан дүгнэлтүүд
- ➔ Төсвийн тухай хууль

Бүх шатны төсөлд хяналт мониторинг хийхдээ иж бүрдэл байдлаар хийхээс гадна тодорхой асуудалд төвлөрөн сэдэвчилсэн байдлаар харьцуулалтыг хийхүйц төвшинд хэд хэдэн байгууллагыг хамруулан хийж болно.

Төсвийн хяналтыг хэрхэн гүйцэтгэх вэ?

Төсвийн хяналтыг дараах алхамтайгаар хийнэ. Үүнд:



Төсвийн хяналтыг хийхэд ямар ур чадвар шаардах вэ?

ИНБ, иргэд хяналт шалгалт хийхийн тулд дараах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байвал зохимжтой. Үүнд:

- Хууль эрхзүйн зохих мэдлэг
- Санхүү, эдийн засгийн шинжилгээний энгийн тооцоолол хийх ур чадвар
- Асуудлыг нэгтгэн дүгнэх, тайлбарлах, түгээх ур чадвар

Төсвийн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах байдлаар хийж болно.

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ



Хүснэгт 4: Үнэлгээний аргачлалууд

Аргачлал	Тодорхойлолт
Төсвийн гүйцэтгэлийн логик холбоосыг үнэлэх аргачлал	Төсвийн төлөвлөлтийн цаад учир шалтгааныг судалдаг. Үнэлгээг хийхдээ өмнөх туршлага, онол арга зүйн үндэслэл бүхий төлөвлөж буй зорилт, арга хэмжээ нь хүлээгдэж буй үр дүнд хүрэх магадлал тодорхойлохыг зорьдог. Төсвийн төлөвлөлтийн зохистой бус байдлаас сэргийлэх ач холбогдолтой.
Төсвийн хэрэгжилтийн өмнөх үнэлгээ хийх аргачлал	<ul style="list-style-type: none"> - Төсвийн хэрэгжилтийн үр дүнг хэмжиж болохуйц байдлаар зорилго, зорилтыг тодорхойлсон эсэх; - Төсвийн хэрэгжилтийг хянах орчин бүрдсэн эсэх. Төсвийн зардал санхүүжилт төсвийн үндсэн зорилго зорилтот нийцэж буй эсэхийг тодорхойлон гүйцэтгэнэ. Төсвийн хэрэгжилтийн үнэлгээг хийхдээ дараах асуудалд төвлөрдөг. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Төлөвлөсөн хөтөлбөрүүд хэрэгжсэн эсэх, хэрэгжилтийн төвшин - Төсвийн хөтөлбөрүүд хэрэгжээгүй шалтаануудад нөлөөлөгч хүчин зүйлс - Төлөвлөлт, гүйцэтгэлийн явцад гарсан гол алдаа зэрэг асуудлууд багтана. Цаашид төсвийн зорилт, гүйцэтгэлийн үр дүнд анхаарах асуудлыг тодорхойлон засаж залруулах зөвлөмж бэлтгэнэ.
Шуурхай үнэлгээ	Төсвийн зардал, санхүүжилт гүйцэтгэлийн байдалд тухайн цаг хугацаанд бодит байдалд үндэслэн хийнэ. Шуурхай үнэлгээг хийснээр төсвийн тодорхой үйл явцын талаар богино хугацаанд дүгнэлт гаргах боломж бүрддэг.
Нөхцөл байдлын судалгаа	Төсвийн зорилго зорилт, хэрэгжилтийн байдалд нарийвчилсан үнэлгээний хийх замаар хэрэгжинэ.

Үр нөлөөний судалгаа	Төсвийн үр дүнд үндэслэгдэнэ. Төсвийн зорилго зорилго, хүрсэн үр дүнгийн хоорондын зөрүүг тодорхойлох замаар хийгдэнэ. Мөн асуудал дэвшүүлэх таамаглах замаар хийж болно.
Мета үнэлгээ	Төсвийн төвлөрүүлэн болон гүйцэтгэх захирагчдын төсөв, гүйцэтгэлд хийгдсэн судалгаа шинжилгээний үр дүнг үндэслэн хийдэг.

3.2 ТӨСВИЙН БАРИМТ БИЧГИЙГ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНД АШИГЛАХ НЬ

Төсвийг боловсруулан дуусаж байна гэдэг нь төсвийн шинжилгээ эхлэхийг сануулж буй хэрэг юм. Өөрөөр хэлбэл, төсвийн төсөл боловсруулж, хууль тогтоох байгууллагад өргөн барих эсвэл олон нийтэд танилцуулах үед төсвийн асуудал өргөн олон нийтийн анхаарлыг хамгийн их татдаг. Ийм учраас энэ үед төсвийн төсөлд үнэлэлт дүгнэлт өгөх иргэний нийгмийн ажил эхлэх учиртай.

Улс орнуудын туршлагаас харахад, төсвийн төсөл, төсөв батлагдах үеийн эхлэл дээр дараах **жишиг асуултууд**-ыг ашиглан, төсвөө эхний байдлаар үнэлдэг байна. Үүнд:

1. Төсвийн тэргүүлэх чиглэлүүд юу вэ?
2. Төсвийн зорилт, тэргүүлэх чиглэлүүд хөгжлийн бодлогын баримт бичиг дэх тэргүүлэх чиглэлүүдтэй адил байна уу?
3. Тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд шаардлагатай төсвийн хуваарилалт хийгдсэн байна уу?
4. Төсөвт тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн сонголтын гол шалтгаан юу вэ?
5. Төсөв хөгжлийн төсөл, хөтөлбөрүүд хаана байршихыг хэлж өгч чадах уу?
6. Төсөв нь татвар, хураамжаас хэчнээн хэмжээний мөнгө босгох вэ? Үүний талаарх үндэслэлтэй тооцоолол байна уу?
7. Төсөв алдагдалтай байна уу? Хэрэв тийм бол төсвийн алдагдлыг хэрхэн санхүүжүүлэх вэ?
8. Төсөв нь урсгал болон хөгжлийн зардлуудыг зөв ялгасан байна уу?
9. Төсөвт ирэх гурван жилийн эсвэл зөвхөн энэ оны тооцооллыг тусгасан байна уу?

10. Төсөв дэх бүх төсөл, хөтөлбөр, дэд хөтөлбөрүүдийн зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон уу?
11. Төсөвт бүх яам, агентлагийн санал болгож буй нийт зардлуудыг хялбархнаар харьцуулах боломжтой хураангуй хүснэгт байна уу?
12. Эрүүл мэнд, боловсрол гэх мэт үйлчилгээний өнөөгийн түвшнийг хадгалахад төсөв хангалттай юу?
13. Төсөв нь зарлагыг хөтөлбөр, дэд хөтөлбөр гэх мэтээр ангилахаас гадна үүнээс илүү нарийвчилсан задаргаатайгаар тооцоолон гаргасан уу?
14. Төсөвт иргэний боловсрол олгох, шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн хөрөнгө мөнгө байна уу?
15. Төсөв нь онцгой байдал, тухайлбал, гамшиг тохиолдоход хэрэглэгдэх яаралтай тусламжийн сантай юу?
16. Төсөв эрх зүйн хүрээнд боловсруулагдсан уу?

Дээр дурдсан асуултуудын хариултыг иргэний нийгмийнхэн болоод мэргэжлийн судлаачид төсвийн үндсэн баримт бичгүүдэд шинжилгээ хийн, олж авдаг. Төсвийн үндсэн баримт бичгүүдийг ашиглан дараах төрлийн дүн шинжилгээ хийж, тойм, үнэлэлт, дүгнэлт гаргаж, олон нийт, хууль тогтоогчид, бодлого боловсруулагчид болон холбогдох яам, агентлагийн албан тушаалтнуудад танилцуулан түгээж болно.

Төсвийн хүрээний мэдэгдэл: Төсвийн хүрээний мэдэгдэл нь иргэний нийгэмд чухал боломж, тухайлбал, засгийн газрын бодлого, төсвийн шийдвэрт нөлөөлөх боломжийг олгодог. Мөн үүнийг үндэслэн макро эдийн засгийн бодлогын зохистой байдлын талаар саналаа илэрхийлж болно. ИНБ-ууд макро эдийн засгийн таамаглал, бодлогын зорилтуудыг үндэслэлтэй гэдэгтэй санал нэгдмэл байсан ч засгийн газраас ялгаатай байр суурь илэрхийлж болно. Хэрэв ИНБ-ууд төсвийн хүрээний мэдэгдэл дэх макро эдийн засгийн таамаглалыг зөв эсэхэд шинжилгээ хийх чадавх сул, мэдээлэл авах боломжгүй байсан ч бусад байгууллагуудын (жишээ нь, олон улсын санхүүгийн байгууллагуудаас гаргасан) хийсэн дүн шинжилгээг ашиглаж, хэлэлцүүлэгт оролцох боломжтой.

Мөн ИНБ-ууд төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн талаар саналаа илэрхийлж болно. Гэхдээ үүнд шинжилгээ хийх нь амаргүй байдаг тул ИНБ-ууд өмнөх оны төсөв дэх бодлогын тэргүүлэх чиглэл, төсвийн хуваарилалттай харьцуулалт хийн, үнэлэлт, дүгнэлт өгч болно.

Төсвийн хүрээний мэдэгдэл нь засгийн газрын бодлого, хөтөлбөр, төсвийн тэргүүлэх чиглэлийн үр дагаврын талаар дүн шинжилгээ хийх хангалттай хэмжээний мэдээллийг агуулсан байх ёстой.

Гүйцэтгэх засгийн төсвийн төсөл: Төсвийн төслийн баримт бичгийг үндэслэн дараах шинжилгээг хийж болно. Үүнд:

- **Төсвийн ерөнхий шинжилгээ:** Төсвийн төсөлд ИНБ-ууд болон төсвийн чиглэлээр ажилладаг судлаачид нарийвчилсан шинжилгээ хийнэ. Энэ нь төсөв, санхүүгийн мэдлэг, ур чадвар ихээхэн шаардсан ажил байдаг тул иргэний нийгмийнхэн өөрсдөө хийхэд хүндрэлтэй бол мэргэжлийн судлаачдаар хийлгэж болно.

Жишээлбэл, Монгол Улсын ННФ-аас төсвөөр мэргэшсэн, хараат бус судлаачдаар “2020 оны батлагдсан төсөв, төсвийн тодотгол, 2021 оны төсвийн төсөл”-д шинжилгээ хийлгэжээ. Уг судалгаагаар 2020, 2021 оны улсын төсвийн төсөөллийн шинэчилсэн тооцоог хийж батлагдсан төсөв, тодотгол болон өргөн барьсан төсөлтэй харьцуулж судалсан байна. Санхүүгийн програмчлал ашиглан эдийн засгийн өсөлт, экспортын үнийн шинэчилсэн төсөөлөлтэй уялдуулан улсын төсвийн төсөөллийг хийжээ. Төсвийн орлогоо хэт өөдрөгөөр төсөөлснөөс засгийн газар зарим төлөвлөсөн зардлаа санхүүжүүлж чадахгүй байх эрсдэлтэй. Төсвийн бодлого нь эдийн засгийн өсөлт, өрхийн амьжиргааг дэмжиж байгаа боловч дотоодын зах зээлээс нийтдээ 2,770 тэрбум төгрөг татахаар байгаа нь урсгал тэнцлийн алдагдал, гадаад валютын нөөцөд дарамт болохоос гадна үүсээд байгаа зээлийн тасалдлыг гүнзгийрэхэд нөлөөлж болзошгүй гэсэн дүгнэлт гаргасан байна. Дэлгэрэнгүй мэдээллийг https://www.forum.mn/res_mat/2020/OSF-Budget2020&2021-Full%20Report-2020-Final.pdf хуудаснаас авах боломжтой.

- **Хууль тогтоогчдод зориулсан товч хураангуй:** Төсвийн ерөнхий шинжилгээг хураангуйлж эсвэл тусгайлсан сэдэвчилсэн байдлаар онцлог, анхаарал татсан асуудлаар цуврал шинжилгээний дүгнэлтүүд бэлтгэн, хууль тогтоогчдод хүргэж болно. Товч хураангуй тайлан болон цуврал материал (бодлогын шинжилгээний цуврал, инфографик мэдээлэл бүхий брошюр гэх мэт) нь хууль тогтоогчдын анхаарлыг татахуйц гол асуудалд чиглэсэн, тэд ойлгоход хялбар байдлаар хийгдсэн байх ёстой.

Жишээлбэл, Монгол Улсын ННФ-аас төсвөөр мэргэшсэн, хараат бус судлаачдаар “2020 оны батлагдсан төсөв, төсвийн тодотгол, 2021 оны төсвийн төсөл”-д шинжилгээний дүнг хураангуйлан бэлтгэжээ. Дэлгэрэнгүйг https://www.forum.mn/res_mat/2020/Budget_2020-2021_Analysis-Summary-Final.pdf хуудаснаас харна уу.

Мөн 2014 онд ННФ-аас улсын төсвийн төсөлд хөндлөнгийн хараат бус тойм дүгнэлт хийж, "Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн төсөл" сэдэвт хэлэлцүүлэгт оролцогч бодлого боловсруулагч, судлаачид, иргэний нийгмийн төлөөлөлд танилцуулжээ. Уг тойм дүгнэлт нь Монгол Улсын Сангийн яамнаас боловсруулсан 2014 оны төсвийн төсөлд харьцангуй богино хугацаа (1 сарын дотор)-нд үнэлэлт, дүгнэлт хийж, хууль тогтоогчид, бодлого боловсруулагчид болон олон нийтэд төсвийн төслийн талаарх мэдээллийг хүртээмжтэй хүргэх зорилтыг тавьсан байна. Дэлгэрэнгүй мэдээллийг https://www.forum.mn/res_mat/OSF/2014%20State%20Budget%20Toim%20Dugnel-OSF.pdf хуудаснаас авна уу.

- **Салбарын шинжилгээ:** Төсвийн санал дах тэргүүлэх салбаруудын эсвэл Засгийн газраас ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө хуваарилсан салбарыг онцолж шинжилгээ хийж болно. Шинжилгээг хийхдээ **харьцуулалтын арга**-ыг ихэвчлэн ашиглана. Өөрөөр хэлбэл, бусад салбарын төсөв эсвэл өмнөх жилийн төсвийн хуваарилалттай харьцуулан дүгнэнэ гэсэн үг.

Жишээлбэл, Боловсролын салбарын шинжилгээг хийхдээ үндэсний, бүс, орон нутгийн түвшинд эсвэл бусад улс орнуудтай харьцуулан дүгнэнэ. Мөн боловсролын сайдын багцыг бусад салбарын сайд нарынхтай харьцуулан, үнэлэлт өгнө. Боловсролын төсөвт шинжилгээ хийхдээ дараах асуултуудад хариулт авахыг чухалчлах хэрэгтэй. Үүнд:

- Боловсролын салбарт хуваарилагдсан төсөв нь тухайн салбарын бодлогын зорилтуудыг биелүүлэхэд хангалттай юу?
- Хуваарилагдсан төсвөөс боловсролын салбарт хангалттай тэргүүлэх ач холбогдол өгсөн гэдэг нь харагдаж байна уу?
- Улсын нийт төсөв (урсгал, хөрөнгө оруулалтын, нийт зардлын)-ийн хэдэн хувь нь тухайн салбарт хуваарилагдсан бэ?
- Бодит байдалд хэр их ахиц дэвшил гарахаар байна?
- Үйлчилгээ үзүүлэх түвшинд боловсролын янз бүрийн хөтөлбөрүүдэд хэр их мөнгө хуваарилагдсан бэ?
- Боловсролын янз бүрийн хөтөлбөрүүдэд хуваарилагдсан хөрөнгө мөнгө өмнөх жилүүдээс нэмэгдсэн байна уу? Мөн дараагийн жилүүдэд бодит хэмжээгээр нэмэгдэх хандлага байна уу?
- Боловсролын янз бүрийн хөтөлбөрт зориулагдсан төсвийн хуваарилалт нь суралцагч хүн амын тодорхой хэсгийг ялгаварлан гадуурхсан эсвэл орхисон байна уу?
- Төсвийн хуваарилалт нь боловсролын хөтөлбөр, ялангуяа ядууст зориулсан хөтөлбөр, үйл ажиллагаанд чиглэсэн байна уу?
- Төсөвлөсөн бүх хөрөнгөө зарцуулахаар хуваарилсан байна уу? Мөн өмнөх жилийн төсвөөс үлдсэн хөрөнгө мөнгө байна уу?

Жишээлбэл, Монгол Улсын Сангийн яамнаас Монголын Статистикийн нийгэмлэгийн судлаачдаар “Хөдөлмөр эрхлэлтийн салбарт зарцуулж буй улсын төсвийн хөрөнгийн жендерийн дүн шинжилгээ” судалгааг 2004 онд хийлгэжээ. Улсын төсвөөс хөдөлмөр эрхлэлтийн салбарт зарцуулж ирсэн хөрөнгийн хэмжээ ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд хангалтгүй, бага байна. Төсөвлөгдсөн бага хөрөнгийн зарцуулалт үр ашиг муутай, зарим тохиолдолд зориулалтын бус зүйлд зарцуулагддаг гэсэн дүгнэлт гарчээ. Уг шинжилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг https://www.forum.mn/res_mat/EmpSector_budget_mong.pdf хуудаснаас харна уу.

- **Хүн амын янз бүрийн бүлгүүдэд үзүүлэх нөлөөллийн шинжилгээ:** Ерөнхийдөө хоёр төрлийн шинжилгээ хийж болно. Нэг нь орлогын янз бүрийн бүлгүүдэд төсвийн зарлагын төсөл, хөтөлбөрийн үзүүлэх нөлөө, нөгөө нь орлогоос бусад шинж байдлаар ангилагдсан бүлгүүдэд үзүүлэх төсвийн хуваарилалтын нөлөөний шинжилгээ юм. Тухайлбал, ядууралд өртсөн хүн амд зориулсан төсөл, хөтөлбөрт зарцуулах хөрөнгийн нийт улсын төсөвт эзлэх хувь хэмжээ, үр нөлөөг судалбал эхний шинжилгээний төрөлд хамаарна. Харин залуучууд, үндэсний цөөнх, эсвэл ахмад настнуудад хуваарилагдсан төсөвт дүн шинжилгээ хийж, нөлөөллийг тогтоовол хоёр дах шинжилгээний төрөлд хамаарна.

Жишээлбэл, Өмнөд Африкийн Эмэгтэйчүүдийн төсвийн санаачилга⁷ нь төсвийн хуваарилалтын эмэгтэйчүүдэд үзүүлэх нөлөөллийг 4 чиглэлд судалжээ: орон сууц, боловсрол, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт. Уг санаачилга иргэний нийгэм, эрдэмтэн судлаачдын хамтарсан судалгаа хийсэн байна. Энэ санаачилгын нэг гол зорилго нь иргэний нийгмийн төсвийн шинжилгээ хийх чадварыг сайжруулах бөгөөд ялангуяа, жендерийн асуудлаар ажилладаг байгууллагуудыг түлхүү хамруулан үйл ажиллагаа явуулжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.undp.org/women/CD-Gender-and-Budgets-2004/4.2-national.htm#1> хуудаснаас үзэж болно.

Мөн Өмнөд Африкийн Африкийн ардчиллын Идаса хүрээлэнгээс НҮБ-ны Хүүхдийн эрхийн конвенцоор тогтоосон хүүхдийн эрх, хэрэгцээг хангах асуудлыг улсын төсөв дэх хүүхдийн хөтөлбөрүүдэд зориулсан хөрөнгийн хуваарилалт тусгасан эсэхэд шинжилгээ хийсэн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.idasa.org.za> хуудаснаас үзнэ үү.

- **Эдийн засгийн ерөнхий байдлын шинжилгээ:** Төсөв нь улс орны эдийн засагт асар их нөлөө үзүүлдэг. Төсвийн төсөл дэх санхүүгийн болон эдийн засгийн таамаглал, үр нөлөөг үнэлэх, ялангуяа түүний

7 IBP, 2016. “Guide to Transparency in Government Budget Reports: How Civil Society Can Use Budget Reports for Research and Advocacy”.

ядууст үзүүлэх нөлөөг үнэлэх нь туйлын чухал. Мөн төсвийн алдагдал, улсын өр төлбөр зэрэгт үзүүлэх нөлөөг үнэлэхээс гадна төсөв эдийн засагт, тухайлбал инфляц, эдийн засгийн өсөлт, ажилгүйдлийн түвшинд ямар нөлөө үзүүлэхийг шинжлэн дүгнэх хэрэгтэй. Санхүүгийн шинжилгээ бол төсвийн шинжилгээний нэг хэсэг бөгөөд эдийн засгийн нөхцөл байдал нь салбарууд болон төсөл хөтөлбөрүүдэд хуваарилагдсан хөрөнгийн хэмжээ, бүтцэд нөлөө үзүүлдэг. Иймд шинжилгээгээр төсөвлөгдсөн орлого, зарлагын тооцоо үндэслэлтэй, үнэн зөв үү? Төсвийн санал дах орлого, зарлагын тооцооллоос шалтгаалсан төсвийн алдагдал байна уу? Эдийн засгийн тэргүүлэх салбаруудад хуваарилагдсан төсвийн хэмжээ хангалттай юу? гэх мэт асуултад хариулт авна.

- **Орлогын шинжилгээ:** Орлогын шинжилгээний нэг гол төрөл бол татварын тогтолцооны хуваарилалтын үр нөлөөний шинжилгээ юм. Төсвийн төсөлд санал болгосон татварын шинэчлэлийн бодлого ядуу эсвэл чинээлэг давхаргын хэнд нь илүү нөлөөлөх вэ? Татварын тогтолцоо шатлан буурсан эсвэл шатлан өссөн татварын тогтолцоо юу? Засгийн газрын гол хөтөлбөрүүдэд тогтвортой дэмжлэг үзүүлэх хангалттай хэмжээний татварын суурь байгаа эсэхийг шинжилгээгээр гаргах хэрэгтэй. Төсвийн төсөл дэх орлогын чиг хандлагыг судлах, тухайлбал, өмнөх жилүүдийн төсвийн орлогуудтай харьцуулах, төсвийн нийт орлогод эзлэх орлогын төрлүүдийн хувь хэмжээг тогтоож, дүгнэлт гаргаж болно.

Жишээлбэл, Монгол Улсын ННФ-ын дэмжлэгтэйгээр хараат бус бие даасан судлаачид “Орон нутгийн төсвийн хуваарилалтыг зохистой хангах нь” судалгааг 2009 онд хийжээ. Уг судалгаагаар, аймаг, сумдын төсөв нь төлөвлөлт, зарцуулалтын хувьд бие даасан байж чадаж байна уу? Орон нутгийн төсвийн татварын болон бусад орлого нь хуулиа оногдсон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хангалттай байна уу? Орон нутгийн төсвийн орлогын гол бүрдэл хэсэг нь ямар төрлийн татварын орлого байна вэ? Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг нь орон нутгийн төсвийн гол бүрдэл хэсэг болох уу? зэрэг асуултад хариултаар авахыг зорьжээ. Судалгааны дэлгэрэнгүй мэдээллийг https://www.forum.mn/res_mat/res_mat-8.pdf хуудаснаас авна уу.

Батлагдсан төсөв: Энэхүү төсвийн баримт бичиг нь төсвөөс хэн хүртэж, хэн хоцорч байгааг иргэний нийгмийнхэн тодорхойлоход тусална. Батлагдсан төсөв дэх мэдээллийг ашиглан өмнөх хэсэгт танилцуулсан төсвийн төслийн баримт бичигт хийгддэг шинжилгээнүүдийг мөн хийнэ. Батлагдсан төсвийг ашиглан илүү гүнзгийрүүлсэн шинжилгээг хийх боломжтой. Учир нь хугацааны хувьд ихээхэн боломжтой байдаг.

Батлагдсан төсвийг хууль тогтоох байгууллагын үүргийг үнэлэн дүгнэхэд мөн ашиглаж болно. Хууль тогтоогчид төсвийг анхны саналын дагуу баталж уу эсвэл иргэний нийгмийнхний болон мэргэжлийн судлаачдын гаргасан санал дүгнэлтэд үндэслэн өөрчлөлт оруулж баталж уу гэдгийг харьцуулан үзэх нь чухал.

Батлагдсан төсөв дэх мэдээллийг ашиглан дараах төрлийн үнэлгээ, тоймыг мөн гаргаж болно. Үүнд:

- **Эдийн засгийн төлөв байдлын тойм:** Батлагдсан төсөв дэх эдийн засгийн төсөөлөл (ДНБ-ий өсөлт, инфляц, ажилгүйдлийн түвшин гэх мэт) болон бодит эдийн засгийн нөхцөл байдлыг харьцуулан, төсөөлөл биеллээ олсон эсвэл хэр их зөрүүтэй байгаад дүн шинжилгээ хийж олон нийтэд тоймлон хүргэж болно.
- **Хөтөлбөрийн гүйцэтгэл ба Төсвийн зарлагын тойм:** Төсвийн жилийн туршид ИНБ-ууд батлагдсан төсөвт тусгагдсан төсөл, хөтөлбөрүүд зарцуулах санхүүжилт төлөвлөгөөний дагуу зарцуулагдсан эсэх, санхүүжигдсэн хөтөлбөрүүд зорилгоо биелүүлсэн эсэхэд үнэлэлт өгч болно. Хэрэв төлөвлөгдсөн болон зарцуулагдсан санхүүжилт хооронд зөрүү гарсан байвал засгийн газраар тайлбар гаргуулах хэрэгтэй.
- **Төсвийн орлогын тойм:** Батлагдсан төсөвт төлөвлөсний дагуу орлого бүрдсэн эсэхэд дүн шинжилгээ хийж болно. Хэрэв орлого бүрдэлт хүлээгдэж буй төсөөлсөн тооцооллоос хол зөрүүтэй бол шалтгаан нь үндэсний эсвэл олон улсын эдийн засгийн тооцоологдоогүй нөхцөл байдлаас үүдсэн эсэх, орлого төлөвлөлт анхнаасаа буруу байсан эсэхэд засгийн газраар дүгнэлт, тайлбар гаргуулах хэрэгтэй.
- **Хагас жилийн тодотгол:** Батлагдсан төсөвт хийгдсэн зарлагын шинжилгээгээр зарлага өссөн, эсвэл зарим төсөл, хөтөлбөрийн санхүүжилт хийгдээгүй үлдсэн байвал шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд шилжүүлэх засварлалт буюу тодотголыг засгийн газарт санал болгож болно.

Иргэдийн төсөв: Энэхүү баримт бичгийг үндэслэн иргэний нийгмийнхэн дараах шинжилгээг хийж болно. Үүнд:

- Иргэдийн төсөв улсын төсөв, түүний тэргүүлэх чиглэлийн талаар хангалттай мэдээлэл олон нийтэд өгч байна уу? Төсвийн баримт бичгүүдийг хэт хураангуйлан бэлтгэгдсэн байна уу? Хэт

хураангуйлснаас иргэдэд шаардлагатай, хэрэгцээтэй мэдээлэл орхигдсон гэж үзвэл ИНБ-ууд өөрсдөө “Иргэдийн төсөв” эмхэтгэл хийж болно. Гэхдээ иргэдийн төсвийн баримт бичгийг бэлтгэх нь засгийн газрын үүрэг юм. Иймд үүнийг заавал бэлтгэх гэж зорих хэрэггүй, гагцхүү мэдээлэл дутуу, хангалтгүй байвал энэ талаар засгийн газарт мэдэгдэж, дараагийн удаад сайжруулахад туслах үүргийг гүйцэтгэх нь илүү зөв алхам болно.

- Хэрэв тухайн улсын засгийн газраас иргэдийн төсвийг маш сайн бэлтгэн, олон нийтийн хүртээл болгодог бол уг баримт бичгийг ИНБ-ууд олон нийтийн төсвийн талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд гарын авлага болгон ашиглаж болно.

Жилийн явцын тайлангууд: Засгийн газар сар, улирлын явцын тайлан гаргаж, олон нийтэд танилцуулах ёстой. Хэрэв ийм тайлангууд гардаг бол ИНБ-ууд төсвийн тооцооны суурь болсон таамаглал төсөөлөл, төлөвлөлт, хэрэгжилтийн чанарыг үнэлэх боломжтой болно. ИНБ-ууд тайлангуудыг ашиглан төсөв төлөвлөгдсөний дагуу хэрэгжиж буй эсэхэд мониторинг хийнэ. Явцын тайлангуудыг ашиглан дараах дүн шинжилгээнүүдийг хийж болно. Үүнд:

- Бэлэн мөнгөний хомсдол бүхий засгийн газрууд төлөвлөсөн хөрөнгө мөнгийг зориулалтын дагуу дутуу зарцуулах тохиолдол байдаг. Иймд ИНБ-ууд жилийн явцын тайлан дах зарцуулалтын тоо, мэдээлэлд дүн шинжилгээ хийн, яагаад дутуу зарцуулалт хийгдсэн талаар засгийн газраас тайлбар гаргуулж, олон нийтэд танилцуулж болно.
- Жилийн явцын тайлангууд нь төсөв батлагдсанаас хойших хугацаанд гарсан өөрчлөлтүүдэд засгийн газар ямар хариу үйлдэл үзүүлж байгааг үнэлэх боломжийг ИНБ-уудад олгоно. Өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэхийн тулд хэт их зардлаа танах эсвэл дутуу зардлаа нөхөхийн тулд зардлаа нэмэгдүүлэх үү гэх мэтэд хариулт болох үнэлгээг ИНБ-ууд засгийн газарт гарган өгч болно.
- Мөн жилийн явцын тайлангууд нь төсөвт шаардлагатай өөрчлөлт оруулах эсэхэд хариулт өгнө. Иймд төсвийн тодотгол хийх хэрэгтэй эсэх, хэрэв хийх хэрэгтэй гэж үзвэл хэзээ, хэдий хэмжээгээр, аль салбарт гэх мэт асуултад хариулт өгөх боломжийг олгоно.
- Онцгой нөхцөл байдал үүсэх, тооцоолоогүй сорилтууд тулгарвал түүнийг хэрхэн даван туулах талаар хариу арга хэмжээ төлөвлөхөд мөн хэрэглэнэ. Үүнийг ИНБ-ууд хараат бус байдлаар бэлтгэж, засгийн газарт өгч болно.

Хагас жилийн тойм: Аливаа улсын засгийн газар төсвийн жилийн эхний зургаан сарын байдлаар хийсэн төсвийн тоймыг бэлтгэж, нийтлэх ёстой. Энэ тоймд батлагдсан төсөвт одоогийн эдийн засгийн нөхцөл байдал нөлөөлж буй эсэх, төсвийн бодлогод өөрчлөлт оруулах эсэхэд үнэлэлт дүгнэлт өгсөн мэдээллийг агуулсан байх учиртай. ИНБ-ууд энэхүү тоймыг ашиглан төсвийн гүйцэтгэлийг хянах, тодотгон засварлах шаардлагатай эсэхэд хариулт өгөх шинжилгээг бэлтгэж болно.

Юуны өмнө хагас жилийн тойм олон нийтэд нээлттэй, ил тод байна уу гэдгийг ИНБ-ууд тодруулах хэрэгтэй. Засгийн газар өөрийн цахим хуудаснаа хагас жилийн тоймыг байршуулсан байх ёстой. Иргэд, иргэний нийгмийнхэн уг тоймыг ашиглан төсөвт тусгагдсан таамаглал, төсөөлөл, тооцоолол хэр бодитой биелэгдэж байгаа, төсөөлөл болон тооцоолол бодитой бус гэж үзвэл өөрчлөх шаардлагатай эсэхэд үнэлгээ өгнө. Харамсалтай нь, дэлхийн цөөхөн улс орнууд хагас жилийн тоймыг маш сайн боловсруулан, олон нийтийн хүртээл болгодог. Гэхдээ ямар нэг байдлаар боловсруулагдан гарсан хагас жилийн тойм дах ерөнхий мэдээллийг ашиглан ИНБ-ууд төсвийн хөтөлбөрүүдийг хэрхэн сайжруулж болох талаар оновчтой зөвлөмж гаргаж болно. Хагас жилийн тоймыг ашиглан ИНБ-ууд дараах шинжилгээг хураангуй хэлбэрээр бэлтгэж болно. Үүнд:

- **Макро эдийн засгийн байдал:** Хэрвээ хагас жилийн тоймд эдийн засгийн байдалд гарсан өөрчлөлтийг харуулсан бол төсөв төлөвлөгдсөний дагуу байна уу эсвэл үгүй юу гэдгийг үнэлэх боломжтой болно. ИНБ-ууд уг мэдээллийг ашиглан төсөв дэх эдийн засгийн байдлын нөлөөг үнэлэх боломжтой. Тухайлбал, төсвийн орлого төсөөлөн тооцоолсноос бага байвал энэхүү орлогын бууралт ямар үр дагавар авчрах вэ? Инфляц, тооцоологдоогүй нөхцөл байдлаас үүдсэн зардлын өсөлт нь төсвийн зарлагыг нэмэгдүүлэх үү?
- **Төсвийн гүйцэтгэлийн үнэлгээ:** Хагас жилийн тойм дах мэдээллийг ашиглан төсвийн зорилтууд биелэгдэж буй эсэхэд үнэлгээ өгч болно.
- **Зарлагын тойм:** Хагас жилийн тоймыг ашиглан зарлагын тооцооллыг дахин шинэчлэн хийж болно. Төсвийн жилийн үлдсэн хугацаанд төсвийн хуваарилалтыг шинэчлэх эсэх, төсвийн ангилал, нэгж хооронд хөрөнгө мөнгийг шилжүүлэх эсэх зэргээр шинэ тооцоолол хийж, олон нийтэд танилцуулж болно.
- **Орлогын тойм:** ИНБ-ууд засгийн газар төлөвлөсний дагуу орлогоо цуглуулж чадсан эсэхэд үнэлэлт өгнө. Зарим тохиолдолд тооцоолсноос илүү их орлого цуглуулагдаад, үүнийг засгийн газар

хууль тогтоох байгууллагын зөвшөөрөлгүйгээр зарцуулахаар болсон бол ИНБ-ууд энэхүү орлогын зарцуулалтыг хянах цорын ганц хараат бус тал болно. Ийм учраас хагас жилийн тойм маш чухал баримт бичиг юм.

- **Төсвийн тодотгол хийх эсэх талаарх үнэлгээ:** Хагас жилийн тоймд хийгдсэн орлого, зарлагын шинжилгээний үр дүнд үндэслэн төсөвт тодотгол хийх эсэхийг шийдэх боломжтой ба үүнийг ИНБ-ууд хийж, засгийн газарт хүргүүлж болно.

Жилийн эцсийн тайлан: Жилийн эцсийн тайлан нь ИНБ-уудад Засгийн газар төлөвлөсний дагуу ажилласан эсэхэд үнэлэлт өгөхөд хэрэгтэй. Жилийн эцсийн тайланд салбарын яамд төсвийн гүйцэтгэлийн давуу болон сул талын талаар хангалттай хэмжээний мэдээлэл, тайлбар оруулж өгвөл ИНБ-ууд үүнийг ашиглан цаашид гүйцэтгэлийг илүү сайжруулахын тулд юу хийх талаар хэлэлцүүлэг өрнүүлж болно. Мөн ирэх жилийн төсөвт баримтлах бодлогын чиглэл, хэрэгжүүлж болох төсөл хөтөлбөрийн талаар хэлэлцүүлгийн суурь болно.

Аудитын тайлан: Энэхүү тайлан нь төсөв амжилттай эсвэл амжилтгүй хэрэгжсэнийг үнэлэхэд шаардлагатай үнэ цэнтэй мэдээллийг агуулсан байдаг. Санхүүгийн тайлангийн аудитын тайланд яам, агентлагуудын илүү, дутуу зарцуулалт, зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүйгээр зарцуулсан хөрөнгө мөнгө, санхүүгийн удирдлагын сул талыг тодотгож өгсөн байдаг. Аудитын тайланг ашиглан ИНБ-ууд дараах төрлийн үйл ажиллагааг явуулж болно. Үүнд:

- **Аудитын үр дүнг олон нийтийн хүртээл болгох:** Ихэнхдээ засгийн газрууд аудитын тайланг дотоод хэрэгцээнд ашигладаг бөгөөд олон нийтийн хүртээл тэр бүр болдоггүй. Иймд ИНБ-ууд аудитын тайлан дах анхаарал татсан асуудлыг олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулан, гүйцэтгэдэг.
- **Яам, агентлагуудын ажлын гүйцэтгэлийн харьцуулалт хийх:** Аудитын тайланд яам, холбогдох агентлагуудын төсвийн гүйцэтгэлийн талаарх дүгнэлт, анхаарал татсан асуудал, зөрчил дутагдлын талаарх мэдээлэл агуулагдсан байдаг тул тэдгээрийг хооронд нь харьцуулан дүгнэсэн үнэлэлт гаргах боломжийг ИНБ-уудад олгодог.
- **Аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг мөшгөх:** Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг хэрхэн хэрэгжүүлснийг хянах ажлыг ИНБ-ууд гүйцэтгэж болно.

3.3 ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ: УЛС ОРНУУДЫН ТУРШЛАГА

3.3.1. Хөтөлбөрийн төсөвт шинжилгээ хийх аргачлал – Өмнөд Африк улс

Өмнөд Африкийн ИДАСА төрийн бус байгууллага нь 1987 онд төсвийн мэдээллийн үйлчилгээ, улс төрийн мэдээллийн хяналтын үйлчилгээ, орон нутгийн засаг захиргааны төв, олон нийтийн саналын үйлчилгээ, Өмнөд Африкийн цагаачлалын төсөл, бүх хэвлэлийн групп төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд байгуулагджээ. Тухайн үед Өмнөд Африкийн нийт хүүхдүүдийн 60 орчим хувь нь ядуу гэсэн судалгааг үндэслэн Засгийн газраас хүүхдийн ядууралтай тэмцэх янз бүрийн ажлуудыг эхлүүлжээ. Тухайлбал, Төсвийн мэдээллийн үйлчилгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ИДАСА 1995 онд улсын төсвөөс хүүхдүүдэд зарцуулж буй төсөвт хяналт хийхээр “Children’s Budget Unit” (CBU) төслийг санаачилсан байна.

Тус байгууллага хүүхдийн эрх, нийгмийн хамгааллын төсвийн хуваарилалт, гүйцэтгэлд хяналт хийх таван үе шаттай стратеги боловсруулан хэрэгжүүлсэн бөгөөд арга зүй, хүрсэн үр дүнг дараах Хүснэгт 5-д нэгтгэн харуулав.

Хүснэгт 5: Хүүхдийн эрх, нийгмийн хамгааллын төсвийн хуваарилалт, гүйцэтгэлд хяналт хийсэн арга зүй, үр дүн

АРГА ЗҮЙ	ҮР ДҮН
Үе шат 1: Хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх Засгийн газрын хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагыг тодотгох.	Хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх дотоодын хууль зүйн орчин бүрэн бүрдээгүй байсан тул олон улсын хууль, тунхгийг баримталсан. Цаашид хариуцагч яамнаас хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны жишиг төлөвлөгөөг цаг хугацааны хэмжүүртэй боловсруулж нийтэд ил зарлаж байхаар болсон. Үгүй бол төрийн бодлого хоосон амлалт төдийхнөөр үлдэх эрсдэл байна гэдгийг мэдэгдсэн.
Үе шат 2: Хүүхдийн ядуурлыг илрүүлэх, хэмжих:	Нийгмийн халамжийн хүртээмж, үр өгөөжийн судалгааг явуулсан. Мөн ядуу өрхийн орлого нэмэгдүүлэх боломжийн судалгаа явуулсан.
Үе шат 3: Төсөл, хөтөлбөрүүдийг тоймлох.	Засгийн газраас хэрэгжүүлж буй хэд хэдэн төсөл хөтөлбөрийн судалгааг дараах асуултуудын хүрээнд нэгтгэсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Засгийн газар хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр боловсруулж чадсан уу? Хэрэв тийм бол, хөтөлбөрийн агуулга, хэрэгжилтийн төлөвлөгөө юу вэ? Ямар байгууллага хэрэгжүүлэгч вэ? - Хэрэв тийм бол, хөтөлбөр нь ялгаварлан гадуурхалгүй, богино хугацаанд зорилгодоо хүрэхээр төлөвлөгдөж чадсан уу? - Хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгийнхнийг бүрэн хамарч чадаагүй бол (хязгаарлагдмал цаг, нөөцийг тооцох) Засгийн газраас орхигдсон хүүхдүүдийг хэдий хэр хугацаанд төсөлд хамруулах ямар төлөвлөгөө байна вэ?

Үе шат 4: Төсвийн хуваарилалт, гүйцэтгэлийн шинжилгээ

Нийгмийн халамжийн төсөвт шинжилгээ хийж, бодит өсөлтийн тооцоог гаргаж ирэхийг зорьсон. Үүний тулд дараах асуултуудыг дэвшүүлсэн. Үүнд:

Төсвийн хуваарилалт

- Хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлснээс хойш улсаас жилдээ хэдий хэмжээний хөрөнгө төсөвлөж байна, ирээдүйд хэдийг төсөвлөхөөр төлөвлөж байна вэ?
- Жилийн нийт зардлын хэдэн хувийг хүүхдийн төсөл, хөтөлбөрийн төсөв эзэлж байна вэ?
- Цаг хугацааны явцад төсөл, хөтөлбөрт төсвийн нэрлэсэн болон бодит нөөцийн хуваарилалт (жилийн дундаж өсөлтийн хурд) ямар хандлагатай байна вэ?

Төсвийн гүйцэтгэл ба хүртээмж

- Хуваарилсан нөөц, хөрөнгийг зориулалтаар нь зарцуулж байна уу, хөтөлбөрийн төсөв хэдэн хувийн зарцуулалттай байна вэ? Засгийн газрын төсвийн хуваарилалт ба төсвийн зардал, төсвийн дутуу/илүү зардал, халамж хүртэгсдийг багцаалж, хөтөлбөрийн тогтвортой байдлыг тооцоол.
 - Хөтөлбөрт хэрхэн хамрагдаж байна? Хөтөлбөрт хамрагдахад хугацаа шаардахгүй, хялбар байна уу? эсвэл дундын байгууллагаар дамжих хүндрэлтэй байна уу?, арьс өнгө, хүйсээр ялгаварлаж байна уу?, хамгийн эмзэг бүлгийнхэн хамрагдаж чадаж байна уу? Хөтөлбөрт хамрагдсан хүүхэд бүр тусламж хүртсэн гэсэн таамаг дээр үндэслэн төслийн зардал, халамж хүртэгсдийн тоог харьцуул. Ялгаварлан гадуурхлыг ядуу/баян дүүрэгт төсөв хэрхэн хуваарилагдсанаар тооцож гаргана.
 - Хөтөлбөрийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, үр өгөөж ямар байна, сайжирсан уу? Хүртээмжийн хомсдол байнга давтагдаж байна уу?, үүнийг шийдэхээр ямар арга хэмжээ авсан бэ?
 - Үйлчилгээний хүртээмжид ямар асуудал (санхүүгийн, санхүүгийн бус) тулгарч байна вэ? Холбогдох төрийн албан хаагчаас хэрэгжилт, асуудлыг хэрхэн шийдэх боломжийн талаар тодруул (хүүхдийн ядуурал ихтэй дүүргүүдэд засаг захиргааны нэгжүүдийн чадавх, хязгаарлалтаас үйлчилгээг хүртээмжтэй түгээж чадахгүй байгаа нь илэрсэн эсэх).
 - Хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд учирч буй хүндрэл, бэрхшээлийг (санхүүгийн, санхүүгийн бус) шийдвэрлэх төлөвлөгөө Засгийн газарт байна уу?
-

Үе шат 5: Үр дүн буюу зөвлөмж

Хүүхдийн эрхийн хэрэгжүүлэх төсвийг хянах энэхүү төслийн хүрээнд төрийн, тухайлан төрийн байгууллагуудын хуулиар хүлээсэн үүрэг, оролцоо тодорхой бус байгааг илрүүлсэн. Тиймээс зарим албаны хүмүүс төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн тухай, ялангуяа нэгдсэн төсвийг тулгасан, баримтаа гаргаж өгөхөөс татгалзаж байсан. Мөн асуудлыг харилцан хамаарал, уялдаатай судлах туршлага, мэдлэг хомс байдгаас судалгаа хийх сонирхол санаачилга сул, мэдээлэл, тоо баримт байхгүй, олдоц муу эсвэл өртөг өндөр гэх мэт асуудлууд тулгарч байсан. Иймээс хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх төсвийн шинжилгээ, хяналт хийхэд дараах мэдээллийг яаралтай бүрдүүлэх хэрэгтэй гэж дүгнэсэн байна. Үүнд:

- Хүүхдийн тэтгэлэг, орлогоор ангилсан
- Хүүхдийн тэтгэлэг нь үндсэн хэрэгцээг хангахад хангалттай эсэх талаарх мэдээлэл
- Хүүхдийн тэтгэлэг нь зорилтот хүн амд хэрхэн тархсан тухай мэдээлэл мужаар, цаашлаад тусламжийн бодит эрэлт хэрэгцээнд
- Мужийн нийт төсөв дүүргүүдэд хэрхэн хуваарилагдаж байгаа, мужийн дотоодод төсвийг хүүхдүүдэд зориулан хэрхэн хуваарилж буй мэдээлэл
- Засгийн газар эцэг эхийн асрамжид байгаа ядуу хүүхдүүдийн нийгмийн хамгааллын тусламжийг бодит болгох үүргээ ирээдүйд биелүүлэх ёстой гэдгийг зөвлөсөн
- Хүүхдийн тэтгэлгийн насны хязгаарыг 17 биш ч 6 наснаас ахиулан тогтоохыг зөвлөсөн
- Нөөцийг бодит нэмэгдүүлснээр, хаана амьдарч байгаагаас үл хамааран ядуу хүүхэд бүр нийгмийн хамгааллын эрхээ тэгш эдлэх боломж олдоно гэж найдаж байна.
- Засгийн газарт алслагдсан хөдөө орон нутагт нөөцийн хуваарилалтыг илүү үр дүнтэй зохион байгуулж, ядуу хүүхдүүдийн тэтгэлэгт хамрагдах боломжийг хаахгүй, эрхээ эдлэх тэгш боломжоор хангахыг зөвлөсөн.

Хүүхдийн төсөвт оролцогч талуудын оролцоог Хүснэгт 6-д харуулсан байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 6: Хүүхдийн төсөвт оролцогч талууд

Оролцогч талууд	Хүүхдийн эрхийг хангахад оролцох байдал	Төсвийн мониторинг
Засгийн газар (Гүйцэтгэх засаглал)	Хууль өргөн барих, төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх (батлагдсан нөөцийн хүрээнд), ядуусын орлогыг нэмэгдүүлэх зах зээлийн орчныг бүрдүүлэх бодлого боловсруулах.	Бодлогын шинэтгэл хийхдээ судалгааны зөвлөмжүүдийг ашиглах.
Парламент	Засгийн газраас хүүхдийн эрхийг хэрхэн хангаж буйд хяналт тавих.	Төсвийг шууд хянах.

Улсын шүүх	Хүүхдийн эрхийн тухай холбогдох хуулийг батлуулах, хэрэгжүүлэх.	Эрхийг хангахыг Засгийн газарт хуулиар үүрэгдэх. Засгийн газар үүргээ биелүүлээгүй тохиолдолд эрхийг шүүхээр шийдэх.
Хүний эрхийн комисс	Засгийн газар хүүхдийн эрхийг хэрхэн хангаж буйг хянах.	Төсвийг хянах.
Эцэг, эх	Хүүхдийн эрүүл, аюулгүй амьдрах үндсэн хэрэгцээний материаллаг, хайр хамгаалал, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх.	Эцэг эхчүүд сургалтаар хүүхдийн эрхийн талаар мэдлэгтэй болдог. Сургалтын төсвийн хянаснаар хүүхдийн эрхийн талаарх ойлголт, төлөвшлийг тогтооно.
Иргэний нийгэм	Хүүхдэд зориулсан үйлчилгээнд олон нийт болон бусад бүлгүүдтэй хамтрах, хүүхдийн эрхийн талаар судалгаа явуулах.	Төсвийг хянах.
Судалгааны байгууллагууд	Хүүхдийн эрхийг хангахад оролцогч талуудын эрх, үүрэг тэдгээрийг хэрэгжүүлэх стратегийг тодорхойлох.	Төсвийн хянах.
Олон улсын санхүүгийн байгууллагууд	Засгийн газрын зээл олгох, хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн хөтөлбөрт санхүүгийн тусламж, техникийн дэмжлэг үзүүлэх.	Нөөцийн хуваарилалтад хяналт тавих.
НҮБ-ийн Хүүхдийн эрхийг хамгаалах хороо	Салбар Хүүхдийн эрхийн хорооны үйл ажиллагааг ажиглах, холбогдох төрийн байгууллага болон ТББ-уудын тайлантай танилцах.	Хүүхдийн эрхийн төсөл хөтөлбөрт төсвийн хуваарилалт хийсэн эсэхийг хянах.
Хүүхдүүд (эрх эдлэгчид)	Эрхээ мэддэг байх.	

3.3.2. Төсвийн орлого, зарлагыг мөшгөх асуулгын арга - Малави улс

Малави улсын төрийн бус байгууллагууд, багш нарын холбоо, шашны байгууллага, дүүргийн сүлжээ байгууллагууд гэх мэт нийгмийн 67 бүлгүүд нэгдэж, Чанартай суурь боловсрол иргэний нийгмийн нэгдэл (ЧСБИНН)-ийг 2000 онд байгуулжээ. Энэ байгууллага нь чанартай боловсрол эзэмших үндсэн эрхийг эдлүүлэх зорилготой бөгөөд зорилгынхоо хүрээнд Дакар 2000, Мянганы Хөгжлийн зорилтуудын зорилгын биелэлтийг урт хугацаанд хянах үүрэг хүлээсэн байна.

Засгийн газраас 1994-2001 онд суурь боловсролыг үнэгүй олгох шийдвэр гаргаж санхүүжилтийг нэмсэн ч ахиц гарсангүй. Иргэд үүнийг төрийн албаны хээл хахуулийн асуудалтай холбоотой хэмээн үзсэн. Боловсролын яамнаас 1999 онд сургуулийн барилгын төсвийн 187 сая малавийн квача буюу ойролцоогоор 1.3 сая ам.доллартой тэнцэх хөрөнгийг шамшигдуулан луйвардсан байх жишээтэй.

Малавийн парламент улсын төсвийн хөрөнгийг дүүргийн мэдэлд зарцуулахаар хуваарилдаг бөгөөд төвлөрсөн бус энэхүү системээс мэдээлэл олж авах гэдэг үнэхээр хүндрэлтэй тул ЧСБИНН нь 13 дүүрэгт боловсролд хуваарилж буй төсвийг мөшгөхөөр зохион байгуулалтад оржээ. Тэд сургуулийн эцэг эхийн зөвлөл, багш нарын холбоо болон бусад боловсролын бүлгүүдийг чадавхжуулах үйл ажиллагаа явуулсан байна.

Хүснэгт 7: Боловсролд хуваарилагдсан зардал мөшгих ажиллагааны арга зүй, үр дүн

Арга зүй

Улсын зардлыг мөшгөх систем (PETS) нь төсвийн нэгдсэн урсгал буюу орлого, зарлагыг мөшгөх арга юм. Мөшгөх тогтолцоог ашигласнаар улсын төсвийн бүх шатан нөөцийг урсгалыг хөөн шүүж цоорхой илрүүлэх боломжтой. Жишээ нь Засгийн газраас сургуулийн засварт хуваарилсан хөрөнгө дүүрэг дамнаад сургуулийн төсөвт орж хэрхэн зарцуулагдсаныг хөөн гаргах юм.

ЧСБИНН нь 2002-2007 оны хооронд асуулга хэрэглэн зардал мөшгөх ажиллагааг гурван удаа зохион байгуулсан. Мөн орон даяар багш, боловсролын салбарын ажилтнууд зориулсан цуврал стандарт асуулга бэлтгэсэн. Сургуулийн захирлуудын асуулга нь сурагчдын (тоо, шалгалтын дүн, сургуулиа орхисон тохиолдол г.м), багшийн (боловсролын байдал, багшийн сул орон тоо, орон байр г.м), цалин олголтын (багш нарын цалинг ихэнхдээ, ялангуяа хөдөө орон нутагт бэлэн мөнгөөр олгодог), заах болон суралцахуйн материалын хүрэлцээ, тоног төхөөрөмжийн хангалт, удирдлага, хариуцлагын тухай асуултууд багтжээ.

ЧСБИНН суурин болон хөдөө орон нутгийн сургуулиас 500 төлөөлөгчийг (ойролцоогоор аравны нэг нь) түүвэрлэн асуулгад хамруулахаар тогтов. Сургуулийн түвшний асуулгаар сургуулиас Сангийн яам руу илгээсэн төсвийн хүсэлт, яамны баталсан төсөв, бодитоор сургуулийн дансанд орсон төсвийн мэдээлэл цуглуулах зорилготой байв. Мөн дүүргийн захиргаа, дүүргийн боловсролын асуудал эрхэлсэн алба, хэлтэс, боловсролын хангамжийн хэлтэс, багш бэлтгэх коллежоос асуулга авав. Үүний зорилго нь Сангийн яаманд гаргасан төсвийн төсөл, бодитоор дүүрэгт хуваарилагдсан төсөв, дүүргээс боловсролын үйл ажиллагааг зохицуулахад гарч буй сар тутмын бодит зардал, яамнаас нэмж олгосон төсвийн хэмжээ, зарцуулалтын зорилго, бага боловсролын зардлын ангилал, гүйцэтгэл гэх зэрэг мэдээллийг цуглуулсан. Асуулгаар цуглуулсан мэдээллийг нэгтгэн дүгнэхдээ:

- төсвийн хуваарилалтын өсөлт;
- боловсролын түвшнээс хамаарах төсвийн зөрүү;
- сургууль, коллежид олгосон материаллаг нөөцийн хэмжээ;
- хүн цагаар тооцсон багшийн цалин;
- ажилд авсан, сургасан багш нарын тоо;
- багш нарын тархац газарзүйн байршлаар;
- сурагчдын элсэлт хүйсээр;
- тусгай боловсролын элсэлт, тэдний материаллаг нөөцийн хангамж зэрэг асуудлуудад анхаарал хандуулж мэдээллийг жилийн тайланг оруулахаар бэлтгэн, гишүүн байгууллагуудад танилцуулж, шаардлагатай тодруулга, засварыг хийж эцэслэн нийтлэв.

ЧСБИНН-ийн асуулга судалгааны тайланг парламентаар жилийн төсөв хэлэлцэн батлах үеэр парламент, засгийн газар, яам, олон улсын хөгжлийн байгууллагууд болон хэвлэлийнхэнд танилцуулж мэдээллийг ил болгосон.

<p>Үр дүн</p>	<p><u>2002 онд</u> Засгийн газраас санхүүжилт байхгүй гэсэн шалтгаанаар Багш бэлтгэх коллежийг хаахад ЧСБИНН Засгийн газар жилд 6000 шинэ багш бэлтгэх үүргээ биелүүлэхгүй байна хэмээн эсэргүүцэн, 3 сарын аян өрнүүлснээр коллежийг дахин нээлгэсэн.</p> <p><u>2003 онд</u> багш нарын цалинг хугацаа хоцорч олгосон, зарим багш нарын цалинг огт олгоогүй гэсэн гомдлын мөрөөр Үндэсний зөвлөлд тайлан гаргаж өгсөн.</p> <p><u>2004 онд</u> Засгийн газар ЧСБИНН-ээс зохион байгуулсан зардлыг мөшгих туршлагыг авч хэрэгжүүлсэн. Тэд төвийн болон дотоод шатны байгууллагын уялдаа холбоог сайжруулахаар ажиллаж эхэлсэн ба багш нарыг орон сууцаар хангах замаар хөдөө орон нутагт ажиллахыг дэмжих арга хэмжээ авсан байна.</p>
<p>Тулгарсан бэрхшээл, сургамж</p>	<p>Засгийн газар төсвийн мэдээллийг бүрэн, бүтнээр нь нийтэлдэггүй.</p> <p>Төрийн албан хаагчдын өгч буй мэдээлэл нь дутуу, эсвэл мэдээлэл өгөхөөс цааргалдаг.</p> <p>ЧСБИНН-ийн гишүүд зөвхөн боловсролын төсвийн мэдээнд дээр л ажиллах чадвартай.</p> <p>ЧСБИНН-ийн гишүүд үндсэн ажлынхаа хажуугаар гүйцэтгэдэг тул заримдаа цагийн боломжоос хамаарч асуулгын боловсруулалтыг хангалтгүй хийдэг.</p> <p>1990 онд төсвийн 28 хувийг эзэлж байсан боловсролын зардал 2005 оны байдлаар 13 хувь болж буурсан нь боловсрол олгох үйл ажиллагаанд нөлөөлсөн г.м.</p>

3.3.3. Худалдан авах ажиллагаанд хяналт хийх арга зүй – Филиппин улс

Худалдан авалтын харуул (ХАХ) төрийн бус байгууллагыг 2001 онд хээл хахуультай тэмцэх хүсэл зорилготой хэсэг иргэд нэгдэн байгуулжээ. Тус байгууллагыг байгуулах үед Филиппинд төр засгийн бараа үйлчилгээний худалдан авалтыг зохицуулах ямар нэг хууль, журам байхгүй, худалдан авалтууд бүрхэг, үл ойлгогдох байдлаар явагддаг байв. Засгийн газрын худалдан авалт хариуцсан зарим албан хаагчид уг байгууллагын Удирдах зөвлөлд гишүүн болсноос хойш 2003 он хүртэлх хоёр жилийн хугацаанд худалдан авалтын хууль зүйн орчныг бүрдүүлэх, сайжруулахыг шаардаж орон даяар аян өрнүүлсэн байна.

Хүснэгт 8: Худалдан авах ажиллагаанд хяналт хийх арга зүй, үр дүн

<p>Арга зүй</p>	<p>ХАХ нь “Дифференциал зарлагын үр ашгийн хэмжилт” (DEEM) аргыг хэрэглэн Засгийн газрын Дотоод аудитын газартай хамтран төрийн алба, үйлчилгээ дэх худалдан авалтын хээл хахуулийг илрүүлэх ажлын гүйцэтгэсэн. Энэ арга нь худалдан авсан бараа, үйлчилгээний үнийг зах зээлийн бодит үнэтэй харьцуулах боломжийг олгодог. Баримт, мэдээлэл дотор зөрчил илэрвэл тэд лавшруулан шалгана гэсэн үг.</p> <p>Худалдан авалтын баримтуудыг худалдан авалтын үйл ажиллагааны шатлалын дагуу 10 маягтад нэгтгэн багцална. Үүнд:</p> <p>Маягт 1: Гүйлгээний тойм, нэхэмжлэлд бичсэн чек (дугаар, огноо, дүн), холбогдох төлбөрийн баримт, мөн гүйлгээг баталсан албан тушаалтан (нэр, албан тушаал)</p> <p>Маягт 2: Худалдан авсан бараа, бүтээгдэхүүний хураангуй</p> <p>Маягт 3: Захиалгын хуудас (дугаар, огноо, хүсэлт гаргасан хэлтэс, нэгж, хүн, хүссэн бараа материал юу болох, баримжаа үнэ, зардал, зорилго, баталсан гарын үсэг г.м)</p> <p>Маягт 4: Худалдан авалтын хуудас, захиалгын хуудас дах мэдээлэл, төлбөрийн баримтын мэдээлэлтэй дүйж буй эсэхийг тулгах, эдгээр баримтын хуулбарыг бараа, үйлчилгээ нийлүүлэгчээс бас авна.</p> <p>Маягт 5: Нэхэмжлэхийн мэдээлэл, худалдан авалтыг үнэлж буй хүнээс төлбөрийн эрхийн бичиг, худалдан авалтын захиалгын мэдээлэлтэй нийцэж байгаа эсэх, зохих албан тушаалтнууд зохих ёсоор гарын үсэг зурсан эсэхийг шалгах.</p> <p>Бусад маягт: Худалдан авалтын бусад шатанд хамаатах тендер зарлахын өмнөх, тендерийн үнэлгээ, тайлагнах явцын хянан шалгалт г.м мэдээллээс гадна жилийн худалдан авалтын төлөвлөгөө, худалдан авалтын хурлын протокол зэрэг мэдээллийг хамардаг.</p> <p>Эдгээр маягтуудыг:</p> <ul style="list-style-type: none"> - Худалдан авалтын хуудас худалдан авалт хийгдсэнээс хойно бичигдсэн байна уу? - Худалдан авалтын хуудас тендерийн үнээс өндөр үнээр бичигдсэн байна уу? - Төлбөрийн хуудасны дүн захиалгын хуудсанд бичсэнээс өндөр байна уу? - Худалдан авсан зүйл төлбөрийн баримт дээрхээс зөрж байна уу? - Нийлүүлэлтийн огноо гэрээ, худалдан авалтын хуудас зэрэгт заасан огноотой ижил байна уу, ямар нэг саад учирсан эсэх гэхчлэн асуултын дагуу нэг бүрчлэн нягтлан шалгана.
<p>Үр дүн</p>	<p>Дифференциал зарлагын үр ашгийн хэмжилт (DEEM)-ээр хийсэн хяналтаар албан хаагчид гэрээг дур мэдэн өөрчилсөн, хамгийн өндөр үнэтэй бараа, үйлчилгээний саналыг тендерт шалгаруулсан гэх зэрэг зөрчил илрүүлсэн.</p> <p>Филиппинд 8000 гаруй мониторингийн мэргэжилтэн шаардлагатай байдаг ч ажиллаж буй мэргэжилтний тоо дөнгөж 800-хан байдаг тул ХАХ ТББ нь худалдан авалтын талаарх сургалт, семинарыг тогтмол зохион байгуулдаг байна.</p>

**Тулгарсан
бэрхшээл,
сургамж**

- Дифференциал зарлагын үр ашгийн хэмжилт (DEEM)-ийн аргаар агентлагуудын худалдан авалтын хууль, журмыг зөрчиж буй дутагдлыг бүрэн илрүүлэх боломжгүй.
- Худалдан авалтын баримт, нотолгоонд нэвтрэх нэн төвөгтэй. Байгууллагад худалдан авалтын хяналт шалгалт оруулах үед байгууллагууд зөрчил илрэхээс айж хамтран ажиллахаас татгалздаг. Баримтаа сайн дураар гаргаж өгөх байгууллага байдаггүй.
- Дифференциал зарлагын үр ашгийн хэмжилт (DEEM)-ийн аргаар зөрчил илрүүлэхдээ аудитын байгууллагатай хамтрах шаардлагатай. Учир нь байгууллага худалдан авалтын баримтаа өгөхөөс татгалзсан тохиолдолд аудитын байгууллагад буй баримтыг үзэх боломжтой.
- Төлбөрийн даалгавар нь бараа/үйлчилгээнд төлсөн бодит өртгийг мэдээлэх боловч зах зээлийн бодит үнийг мэдээлдэггүй.

3.3.4. ИНБ/Иргэний аудит – Өмнөд Солонгос улс

Өмнөд Солонгосын Аудит, хянан шалгах газар (BAI) 1963 онд байгуулагдсан. Хээл хахууль авах, улсын нөөцийг шамшигдуулах зэрэг үйл ажиллагаа төр, иргэдийн итгэлцэлд сөргөөр нөлөөлдөг тул тус газар иргэдээс аливаа санхүүгийн залилан, зүй бус үйлдэл, эрх мэдлээ урвуулан ашиглаж буй мэдээлэл, гомдол хүлээн авах Иргэний өргөдөл, гомдлыг хүлээн авах төвийг 1971 онд байгуулсан байна. Улмаар, 1993 оноос улсын нөөц, төрийн захиргааны санхүүгийн гомдол хүлээн авах интернэтийн (#188) утас ажиллуулж эхэлсэн ба 2004 оноос бизнесийн засаглалтай холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авдаг болж өргөжүүлжээ.

Аудит, хянан шалгах газраас 1996 онд Нийтийн ашиг сонирхлын аудитын хүсэлтийг батлуулснаар 300-аас дээш гишүүнтэй төрийн бус байгууллага эсвэл 19-өөс дээш насны 300 болон түүнээс дээш тооны иргэд эвлэлдэн нэгдэж нийтийн ашиг сонирхлын төлөө аудитын хянан шалгалт хийх хүсэж өргөдөл гаргах хууль эрхзүйн орчин бүрджээ.

Хүснэгт 9: Аудитын шаардлага, хамрах хүрээ

	Иргэний аудитын хүсэлт	Нийтийн ашиг сонирхлын аудитын хүсэлт
Аудит шаардах эрх	19-өөс дээш насны 300 болон түүнээс дээш тооны иргэдийн бүлэг	19-өөс дээш насны 300 болон түүнээс дээш тооны иргэдийн бүлэг
		300-аас дээш гишүүдтэй ИНБ
		Төрийн байгууллагын удирдлага
		Орон нутгийн зөвлөл

Аудитын хамрах хүрээ	Хууль бус үйлдэл/хээл хахууль	Хууль бус үйлдэл/хээл хахууль
		Төсвийн хэтрэлт
		Буруу менежмент
		Нийтийн ашиг сонирхолд хамаатах бусад асуудал
Аудитын хүсэлтэд үл хамаатах асуудал	Мөрдөн байцаалт, шүүх хурлын шатанд байгаа асуудал	Мөрдөн байцаалт, шүүх хурлын шатанд байгаа асуудал
	Хувийн ашиг сонирхлын асуудал	Хувийн ашиг сонирхлын асуудал
	Орон нутгийн шүүх захиргааны харьяа асуудал	

Аудит, хянан шалгах газар жилдээ 150 байгууллагыг хянан шалгах төлөвлөгөөтэй ажилладаг ба иргэд, олон нийтээс ирүүлсэн 150-180 орчим хүсэлт, гомдлоос 20-30 түүвэрлэн авч нэмэлтээр шалгалт оруулдаг байна.



Аудит, хянан шалгах газрын төлөвлөгөөт шалгалтууд 180 хоногт, харин иргэд, ТББ-ын хүсэлтийг хянан, шалгалт явуулах бол шалгах эсэхээ мэдэгдэх 30 хоног, шалгах 60 хоног, үр дүнг эргэж мэдээлэх 10 хоног буюу нийт 100 хоногт багтаах хуваарьтай.

Хүснэгт 10: Аудит хийх хугацаа

	Төлөвлөгдсөн аудит	Аудитын хүсэлт
Санаачлагч	Аудит, хянан шалгах газар	Хүсэлт, гомдол
Ажлын цар хүрээ	Өргөн, цогц	Тодорхой, чиглэсэн
Аудитын баг	10-аас дээш хүн	1-2 аудитор
Ажиллах хугацаа	Хоёр долоо хоногоос дээш	2-5 хоног

Цаашлаад, Аудит, хянан шалгах газар, төрийн бусад байгууллагуудтай амжилттай зөвшилцсөний үр дүнд Төрийн байгууллагын дотоод аудитын актыг 2010 онд байгуулж төрийн байгууламжийн санхүүгийн дотоод аудит, хянан шалгахтай холбоотой иргэдийн санал, гомдолд хариу өгөх нөхцөл бүрдүүлжээ.

ШИГТГЭЭ 7: Иргэд, хэрэглэгчдийн хүсэлт гомдлын дагуу хийгдсэн хяналт шалгалт, үр дүн – Өмнөд Солонгос

Жишээ 1: Им-сёон мужийн орон нутгийн захиргаа орон нутагтаа үйлдвэрлэлийн томоохон төв барихаар 42 тэрбум воны өрийн баталгаа гаргахаар шийджээ. Муж санхүүгийн эрсдэлээ даалгүй дампуурах аюултайг мужийн иргэд тооцоолон мужийн захиргааны шийдвэр холбогдох хууль, журамд нийцсэн эсэхийг шалгуулахаар өргөдөл гаргасныг нягтлан шалгаад, мужийн захиргаа хувийн компанид өрийн баталгаа гаргах нь хууль зөрчсөн явдал болохыг тогтоож, мужийн захиргаанд шийдвэрээ цуцлахыг үүрэгдсэн.

Жишээ 2: Үүрэн утасны компани хэрэглэгчдийн зөвшөөрөлгүй “үнэтэй” тариф төлөвлөгөөнд оруулсан тухай олон хэрэглэгчид гомдол мэдүүлсний дагуу Аудит, хянан шалгах газар аудитын шалгалт оруулж хоёр сая илүү зөрчил илрүүлжээ. Шалгалтын үр дүнг Солонгосын Харилцаа Холбооны Хороонд мэдүүлсэн ч хариу арга хэмжээ авахгүй байсан тул Аудит, хянан шалгах газар тухайн компанид торгууль ноогдуулж, нийт хэрэглэгчдээс зөвшөөрөлгүй хураасан бүх төлбөрийг нөхөн олгуулсан.

Аудит, хянан шалгах газар иргэдийн мэдээллийн дагуу шалгалт хийснээр төрийн болон бизнесийн байгууллагын санхүүгийн аудитын бие даасан байдал алдагдсан, аудиторуудын мэргэжлийн ур чадвар муу, төрийн албаны дотоод дах хээл хахуулийн сүлжээ гэх мэтчилэн олон зөрчлийг илрүүлж тэдгээрийг арилгах арга хэмжээ авдаг болсон байна.

Өмнөд Солонгосын Аудитын Ерөнхий Газар (SAI) аудитын үйл ажиллагаанд иргэдийг оролцуулах нь аудитын бие даасан байдал алдагдах, хянан шалгах зардал хомс гэх мэт шалтгаанаар аудитын үйл ажиллагаанд иргэд, ТББ-ын оролцоог дэмждэггүй байв. Иймд санхүүгийн засаглалыг сайжруулах оролцоот аудитын аргачлалыг амьдралд нэвтрүүлэх, хөхүүлэн дэмжих үүднээс 300-аас дээш иргэд эсвэл төдийн тооны гишүүдтэй ТББ хянан шалгуулах хүсэлт гаргах боломжийг хуульчлан баталгаажуулсан. Өмнөд Солонгос улсад 2001 онд 3,236 төрийн бус байгууллага бүртгэлтэй байсан ч 2011 онд 10,086 хүрсэн нь иргэд эвлэлдэн нэгдэж эрхээ эдлэх, ашиг сонирхлоо хамгаалах хүсэлтэй байгаагийн илрэл бөгөөд сүүлийн үед цахим орчин дах иргэдийн нэгдэл их болсон.

Иргэдийн оролцоот аудитын үйл ажиллагаанд ажиллагдаж буй сөрөг үр дагаврыг дурдвал:

- Сонгуулийн жилүүдэд өрсөлдөгчөө “улс төрийн зорилгоор” шалгуулах хүсэлтийн тоо огцом өсдөг.
- Иргэдийн цахим нэгдэл нь ач холбогдол багатай асуудлыг хөөрөгдөн аудитын нөөцийг үр дүнгүй аудит шалгалтад зарцуулах шахалт үүсгэдэг.
- Аудитын Ерөнхий Газар (SAI) нь иргэдийн оролцоот аудитын аргачлалыг дэмждэггүй тул иргэдийн оролцоотой хянан шалгах ажиллагаанд ахиц төдийлөн харагдахгүй байгаа ажээ.

Дээр дурдсан сөрөг үр дагаврыг бууруулахын тулд:

- Тодорхой бүлгийн **хувийн** ашиг сонирхлыг бодитоор хязгаарлах замаар иргэдийн оролцоог аудитыг дэмжих;
- Аудит, хянан шалгах газар иргэдтэй хамтран аудитын зөвлөмжүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж байгааг өргөтгөн иргэдийн оролцоотой аудитын үр дүнг дахин нягтлах систем бий болгох;
- Иргэдийн оролцооны аудитын санаачилгыг дэмжих, хэвшүүлэхийн тулд хууль эрх зүйн нэгдмэл орчныг бүрдүүлэх;
- Иргэдийн оролцоотой аудитын үнэ цэнэ, үр өгөөжийг бодитоор үнэлж, аудитын үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах сурталчилгааг тогтмол явуулах г.м ажлуудыг хийж байна.

3.3.5. Төсвийн гүйцэтгэлийг хянах онооны картын арга – Эстони улс

Эстони улсад нийт 235 музей байдгаас 20 хувь нь улсын, 50 хувь нь орон нутгийн захиргааны, 25 хувь нь хувийн, үлдсэн 5 хувь олон нийтийн хуулийн байгууллагуудын дэд нэгжүүдэд харьяалагддаг байна. Эдгээр музейд Эстонийн Соёлын яамны эрхлэх асуудалд багтаж шаталсан ангиллаар 11 музейд захирагддаг байна. Тэдгээрийн толгой музей нь 1909 онд Тарту хотод байгуулагдсан Эстонийн Үндэсний музей юм. Энэ музей нь Эстонийн түүхэн, бүдгэрч буй соёлын өвийн i) цуглуулга, хадгалалт хамгаалалт, (ii) шинжилгээ судалгаа, (iii) үзэсгэлэн, арга хэмжээ, (iv) музейн заах аргазүй, боловсрол гэсэн дөрвөн үндсэн чиглэлд үйл ажиллагаа явуулдаг.

Эстонийн Засгийн газраас 2005 онд баталсан "Стратегийн хөгжлийн төлөвлөгөө, системийн төрөл ба тэдгээрийг мөрдөх, хэрэгжүүлэх, үнэлэх, тайлагнах тухай" тогтоолд улсын байгууллагууд стратегийн хөгжлийн

төлөвлөгөөнийхөө гүйцэтгэлийг тайлагнаж байхаар тусгажээ. Энэхүү шинэтгэлийн бодлогын хүрээнд тус музейн гүйцэтгэлийг тэнцвэрт онооны картын аргаар хэмжихээр болжээ.

Хүснэгт 11: Тэнцвэрт онооны картын арга зүй, үр дүн

Арга зүй

Тэнцвэрт онооны карт (BSC) гэдэг нь 1-т санхүүгийн, 2-т хэрэглэгчийн, 3-т дотоод үйл ажиллагааны, 4-т сургамж, өсөлтийн үзүүлэлтээр байгууллагын гүйцэтгэлийг хэмжих систем юм. Дэвид Нортон, Роберт Каплан нар 1992 онд өмнө нь хэрэглэгдэж байсан гүйцэтгэлийг хэмждэг үзүүлэлтүүдийг санхүүгийн бус мэдээллээр баяжуулан Тэнцвэрт онооны картын (BSC) аргачлалыг боловсруулжээ. Тэнцвэрт онооны картын аргачлалыг анх ашгийн төлөө компаниудад хэрэглэж байсан ч хожим нь ашгийн бус мөн төрийн байгууллагуудад ашиглахаар тохируулан өөрчилсөн байна. Улсын болон төрийн бус байгууллагын гүйцэтгэлийг доорх гурван ангиллаар хэмжиж болно. Үүнд:

- Оролтын хэмжүүр - хүний нөөц, төсвийн нөөц гэх мэт хөтөлбөрүүдийн оролтыг мөшгөх
- Гаралтын хэмжүүр - хөтөлбөрийн хүрээнд ямар үйлчилгээг хэдэн хүнд хүргэсэн г.м
- Үр дүнгийн хэмжүүр - Зорилтот хүнд амд эерэг нөлөө үзүүлсэн эсэх.

Үр дүн

Төв музей нь улсын төсвөөс санхүүждэг учир музейн гүйцэтгэлийг хэмжих нь төдийлөн ач холбогдолгүй мэт байлаа. Соёлын яам музейн захиргаа, үйл ажиллагааны зардлыг төлөх үүрэгтэй ч музейгээр үйлчлүүлэгчдийн тоо буурахгүй, сэтгэл ханамж өндөр байсан тохиолдолд санхүүжүүлнэ гэсэн нөхцөлийг музейд тавьжээ.

Яамны санхүүжилтийн нөхцөл нь музейн дотоод үйл ажиллагааг өөрчлөх хөшүүрэг болсон. Музей үзэгчдийнхээ тоог тогтвортой хадгалах, нэмэгдүүлэхийн тулд ажилтан, ажилчдынхаа мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, улмаар музейн үйлчилгээ, арга хэмжээг олшруулах зэргээр дотоод үйл ажиллагаандаа анхаарч, өөрчлөлт хийх шаардлага тулгарсан. Музейн бүх хэлтэс, нэгжүүд тус бүрдээ үйл ажиллагааны зардлын болон дотоод нөөцийн тооцоо хийж санхүүгийн зорилт, тэдгээрийг хэмжих үзүүлэлтээ тодорхойлов. Музейн санхүүжилт нийт ажилтнуудын “нийтлэг” асуудал болов. Музей санхүүгийн дадлаа өөрчлөхөөс гадна нэмэлт орлого олох боломжуудыг хайж эхэлсэн.

Төв музейд өрнөсөн шинэчлэлийн үр дүнд хэвтээ тэнхлэгийн буюу музейн хэлтэс, нэгжүүдийн дотоод хамтын ажиллагаа, бүтээлч байдал эрс сайжирсан. Мөн босоо тэнхлэгт яам болон музейн удирдлагын хамтын ажиллагаа, харилцан ойлголцол нэмэгдсэн. Өөрөөр хэлбэл, музейн санхүү, үйл ажиллагааг ухаалгаар удирдаж, гүйцэтгэлд нөлөөлснөөр үйлчилгээ, бүтээгдэхүүний үр өгөөж, хүртээмж нэмэгдэж иргэд, үйлчлүүлэгчдийн хэрэгцээг хангах зорилгод ахиц гаргажээ.

Схем 1: Тэнцвэрт онооны картын загвар



3.4 ТӨСВИЙН СУРТАЛЧИЛГАА, НӨЛӨӨЛӨЛ

Төсвийн шинжилгээ, хяналтын үр дүнг олон нийт, хууль тогтоогчид, бодлого боловсруулагчдад мэдээлж, төсөвт тодорхой шаардлагатай өөрчлөлт оруулж, төсвийн үр ашгийг дээшлүүлэх, гүйцэтгэх засаглалын хариуцлагыг нэмэгдүүлэхийн тулд төсвийн тухай болон төсвийн шинжилгээ, хяналтын үр дүнгийн ухуулга, нөлөөллийн кампанит үйл ажиллагааг зайлшгүй явуулах хэрэгтэй. Төсвийн талаарх ухуулга, нөлөөллийн үйл ажиллагааны хамгийн чухал элемент бол төсөв, төсвийн шинжилгээ, хяналтын үр дүнг үнэн зөвөөр түгээн тархаах/дэлгэрүүлэх явдал юм.

Төсвийн шинжилгээ, хяналтын үр дүнг яаж түгээх вэ?

Үр дүнг түгээн тархаах/дэлгэрүүлэх үйл ажиллагааг дараах байдлаар явуулж болно. Үүнд:

- Хүчирхэг, эрх мэдэл бүхий оролцогч талуудтай хувийн уулзалт хийх;
- Хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлэхийн тулд олон нийтийн уулзалтууд зохион байгуулах;

- УИХ-ын гишүүдийг оролцуулсан хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулах;
- Бүх оролцогч талуудтай мэдээлэл солилцох эсвэл хуваалцахын тулд семинар, хурал, зөвлөгөөн зохион байгуулах;
- Жагсаал, өргөх бичиг, тайван жагсаал
- Хэвлэлийн тойм
- Олон нийтийг оролцуулсан өдөрлөг, аян

Төсвийн шинжилгээ, хяналтын үр дүнг хэрхэн үр дүнтэй түгээх вэ?

- Үр дүнтэй түгээх/дэлгэрүүлэхийн тулд юун түрүүн цаг үеэ олсон чухал уулзалтуудыг зохион байгуулж, шийдвэр гаргуулах;
- Хүргэхийг зорьсон үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг агуулсан хэвлэмэл болон цахим материалууд хүртээмжтэй, энгийн үг хэллэгтэй, инфографик зураг, дүрслэл агуулсан байх;
- Хүргэхийг зорьсон гол мессежийг зорилтот оролцогч талд хүргэхдээ товхимол, брошюр, эмхэтгэл, хөтөч, тойм, сонин эсвэл сэтгүүлийн нийтлэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, цуврал, судалгааны тайлан гэх мэт олон хэлбэрээр бэлтгэх.

Төсвийн үе шат бүрт ИНБ-ууд оролцож, төсөв, төсвийн шинжилгээ, хяналтын үр дүнгээ лобби бүлэг, түншлэл, сүлжээ, хэвлэл мэдээлэл, олон нийтийн оролцоотойгоор танилцуулахаас гадна тэднийг төсвийн үйл явцад оролцохыг зөвлөх, өдөөх, дэмжих зэргээр хамтран ажиллаж, төсвийн үйл явцыг сайжруулахад хувь нэмрээ оруулах хэрэгтэй. Тухайлбал,

Төсөв боловсруулах: Иргэний нийгэм нь төсвийн хуваарилалтад дараах байдлаар нөлөөлнө. Үүнд:

- Хэрэгцээ шаардлагыг тодорхойлох;
- Төсвийн мэдээлэл түгээх, солилцох;
- Төсвийн хувилбарууд боловсруулах.

Төсөв батлах: Төсвийн мэдээллийг дараах байдлаар нийтийн хүртээл болгоно. Үүнд:

- Хууль батлах үйл явцыг нээлттэй болгох кампанит ажил
- Төсвийн тойм хэвлэн нийтлэх
- Хэвлэл мэдээлэл (мэдээллийн хэрэгсэл ашиглах), албан

тушаалтнууд (мэдээлэл олж авах, мэдээллээ солилцох), олон нийт (төсвийн үйл явцыг илүү нээлттэй, ил тод болгоход дарамт шахалт үзүүлэх)-тэй хамтран ажиллах.

Төсвийн гүйцэтгэл: Төсвийг төлөвлөсний дагуу зарцуулсан эсэхэд хариуцлага тооцох чиглэлд дараах байдлаар ажиллана. Үүнд:

- Төсөв, төсвийн үйл явцын сурталчилгаа, нөлөөллийн бүлэг ажиллуулах
- Төсвийн шинжилгээ, хяналтын үр дүнг түгээх, үр нөлөөг хэмжих

Тайлагнал, аудит: Төсвийн үр нөлөөг үнэлэх чиглэлд дараах маягаар ажиллана. Үүнд:

- Хүн амын янз бүрийн бүлэгт үзүүлэх үр нөлөөг судлах
- Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг хянах
- Дараагийн жилийн төсвийн хуваарилалтыг сайжруулахад хэрэгтэй санал, зөвлөмжийг боловсруулах.

Төсвийн шинжилгээ, хяналтын үр дүнгийн сурталчилгаа, нөлөөллийг хийхдээ үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, стратегитай ажиллах хэрэгтэй. Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргахдаа дараах хүснэгтийг бөглөж, өгөгдсөн мэдээллийг ашиглан, төлөвлөгөө зохион, ажиллах нь илүү үр дүнтэй.

Хүснэгт 12: Төсвийн сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааны нэгтгэл

Төсвийн үе шат	Сурталчилгаа, нөлөөллийн зорилго	Нөлөөлөхийг хүссэн төслийн баримт бичиг	Зорилтот оролцогч тал	Хамтрагч, түншлэл, сүлжээ	Гол асуудал	Шаардлагатай мэдээлэл
Төсөл боловсруулах						
Төсөл батлах						
Төсвийн гүйцэтгэл						
Тайлагнал, аудит						

Төсвийн сурталчилгаа, нөлөөллийн эцсийн зорилго бол төсвийн хуваарилалт, төсвийн бодлогод өөрчлөлт оруулж, үр ашгийг дээшлүүлэх юм.

Тийм учраас төсвийн сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг янз бүрийн хэлбэр, төрлөөр хийж эцэст нь тухайн улсад төсвийн ил тод, нээлттэй байдал хангагдах учиртай. Нөлөөллийг үр дүнтэй хийхийн тулд иргэд, ИНБ-ууд, сонирхлын бүлгүүдийн ойлголтыг дээшлүүлэх, тэднийг дайчлах, сонирхлыг өдөөх, хандлагын өөрчлөлтийг дэмжих, олон нийтийн дарамт шахалт үзүүлэх кампанит ажил явуулах, бодлогын танилцуулга цуврал бэлтгэх, олон нийтийг хамарсан ухуулга сурталчилгааны арга хэмжээ зохион байгуулах, гүйцэтгэх засаглалынхантай шууд уулзалт, хэлэлцүүлэг хийх, түншлэл, холбоо, сүлжээнд нэгдэж дуу хоолойгоо хүргэх зэрэг олон стратеги арга хэмжээг авч болно.

ТӨСВИЙН ҮР ДҮНТЭЙ СУРТАЛЧИЛГАА, НӨЛӨӨЛӨЛ



Төсвийн сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг зорилго, хэрэглэгч буюу оролцогч, шийдвэр гаргалт зэргээс дараах төрлүүдэд хувааж болно. Үүнд:

- **Чадавх бэхжүүлэх:** Төсөв, санхүүгийн чиглэлээр ажилладаг ИНБ-ууд бусад ИНБ-ууддаа сургалт явуулж, тэдний төсвийн үйл явцад оролцох сонирхол, чадавхыг дээшлүүлэхэд тусалж болно. Мөн ИНБ-ууд төрийн албан тушаалтнуудтай (эсвэл олон улсын байгууллагуудтай) хамтран ажиллаж, төсвийн үйл явцад өөрсдийн чадавхыг бэхжүүлдэг. Үүний үр дүнд төсвийн үйл явцад илүү хүчтэй оролцож, хяналт сайжирна.
- **Судалгаа, шинжилгээний ажил:** Төсвийн шинжилгээ, хяналтын мэдээллээ бусадтай хуваалцаж, мэдээлэл солилцоноор ИНБ-ууд төсвийн шинжилгээнд өөр хандлага боловсруулах, төсвийн мэдээллийг өөр өнцгөөс шинжлэх, бодлогын чухал асуудлуудыг илрүүлэх чадвараа сайжруулдаг.

